

Бага эмчийн мэргэжлээр эмчлэх зөвшөөрөл олгох шалгалтын жишиг сорил-1

Сорилын зөв хариулт

1-Е, 2-С, 3-В, 4-А, 5-Е, 6-А, 7-А, 8-Е, 9-А, 10-Е, 11-С, 12-А, 13-В, 14-В, 15-А, 16-В, 17-
D, 18-Е, 19-А, 20-А, 21-Е, 22-Е, 23-В, 24-А, 25-А, 26-В, 27-А, 28-А, 29-Е, 30-С, 31-А,
32-Е, 33-В, 34-Е, 35-А, 36-С, 37-А, 38-А, 39-С, 40-А, 41-Е, 42-Е, 43-А, 44-Е, 45-А, 46-Е,
47-С, 48-Е, 49-Е, 50-А, 51-D, 52-Е, 53-А, 54-В, 55-Е, 56-А, 57-В, 58-А, 59-А, 60-А, 61-В,
62-С, 63-Е, 64-Е, 65-А, 66-Е, 67-А, 68-Е, 69-Е, 70-С, 71-А, 72-Е, 73-А, 74-А, 75-А, 76-А,
77-А, 78-Е, 79-Е, 80-А, 81-Е, 82-Е, 83-D, 84-А, 85-А, 86-Е, 87-Е, 88-А, 89-Е, 90-А, 91-Е,
92-Е, 93-Е, 94-Е, 95-Е, 96-А, 97-Е, 98-Е, 99-В, 100-А, 101-А, 102-В, 103-С, 104-А, 105-
Е, 106-С, 107-В, 108-D, 109-D, 110-D, 111-В, 112-D, 113-В, 114-D, 115-В, 116-D, 117-В,
118-А, 119-А, 120-Е, 121-А, 122-А, 123-С, 124-С, 125-С, 126-D, 127-С, 128-Е, 129-В,
130-В, 131-А, 132-А, 133-А, 134-А, 135-А, 136-D, 137-С, 138-А, 139-В, 140-В, 141-А,
142-D, 143-В, 144-С, 145-D, 146-В, 147-В, 148-А, 149-В, 150-А, 151-D, 152-Е, 153-С,
154-С, 155-D, 156-В, 157-С, 158-С, 159-С, 160-В, 161-D, 162-С, 163-D, 164-А, 165-А,
166-А, 167-В, 168-D, 169-Е, 170-А, 171-D, 172-D, 173-В, 174-В, 175-D, 176-А, 177-А,
178-А, 179-D, 180-С, 181-D, 182-С, 183-D, 184-В, 185-В, 186-D, 187-С, 188-А, 189-D,
190-А, 191-D, 192-D, 193-D, 194-А, 195-D, 196-С, 197-С, 198-А, 199-А, 200-А, 201-С,
202-Е, 203-А, 204-В, 205-Е, 206-А, 207-Е, 208-Е, 209-Е, 210-А, 211-Е, 212-Е, 213-А,
214-Е, 215-А, 216-А, 217-D, 218-А, 219-А, 220-А, 221-С, 222-А, 223-В, 224-С, 225-В,
226-В, 227-В, 228-А, 229-Е, 230-А, 231-А, 232-Е, 233-А, 234-Е, 235-С, 236-А, 237-Е,
238-В, 239-А, 240-Е, 241-Е, 242-А, 243-Е, 244-В, 245-Е, 246-Е, 247-А, 248-С, 249-А,
250-А, 251-Е, 252-Е, 253-D, 254-А, 255-А, 256-А, 257-С, 258-Е, 259-Е, 260-Е, 261-Е,
262-Е, 263-А, 264-А, 265-Е, 266-С, 267-С, 268-Е, 269-А, 270-В, 271-Е, 272-А, 273-Е,
274-А, 275-А, 276-Е, 277-А, 278-Е, 279-Е, 280-А, 281-С, 282-А, 283-А, 284-D, 285-Е,
286-А, 287-Е, 288-А, 289-В, 290-Е, 291-А, 292-С, 293-Е, 294-А, 295-Е, 296-Е, 297-А,
298-В, 299-Е, 300-Е, 301-Е, 302-В, 303-А, 304-В, 305-Е, 306-Е, 307-А, 308-Е, 309-А,
310-В, 311-В, 312-В, 313-А, 314-А, 315-А, 316-А, 317-А, 318-С, 319-А, 320-Е, 321-Е,
322-Е, 323-В, 324-Е, 325-А, 326-Е, 327-А, 328-С, 329-Е, 330-А, 331-Е,

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, Е гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)
 - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (А.)
 - 1 ба, 3 дугаар хариултууд зөв бол (В.)
 - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (С.)
 - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
 - Бүх хариулт зөв бол (Е.)
3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
 - Зөв, Зөв, Зөв (А.)
 - Зөв, Зөв, Буруу (В.)
 - Зөв, Буруу, Буруу (С.)
 - Буруу, Зөв, Буруу (D.)
 - Буруу, Буруу, Буруу (Е.)

/1./ Татрангийн халдварыг ямар замаар авч болох вэ?

1. Ямар нэг шарх, хатиг бохирлогдоход
2. Түлэгдэлт, хөлдөлтийн шархаар
3. Хууль бус үр хөндөлтийн явцад
4. Хэвтрийн холголт, цооролтоор
5. Хавдрын ургац задарч шарх болж, түүнд халдвар орсон тохиолдолд

/2./ Механик буюу элэгний доорхи шарлалт ямар шалтгаантай үүсдэг вэ?

1. А, В, С, Д, Е вируст гепатит

2. Нойр булчирхайн толгойн хавдар
 3. Үжил, хумхаа, хорт цус багадалт, туяаны өвчин
 4. Цэс чулуужих өвчин, цэсний ерөнхий цоргоны нарийсал
 5. Элэгний өмөн, лептоспироз, моноклеоз, архаг гепатит С
- /3./ Менингит нь халуурах шалтгаан болж буйг ямар шинжүүдээр батлах вэ?
1. Толгой хүчтэй өвдөх
 2. Ханиалгах, цэр гарах
 3. Дагзны булчин хөшингө болох
 4. Хэвлийн булчин чангарах
 5. Шээс цустай гарах
- /4./ Хүүхдийн түвэнхийн үрэвсэл, нарийсал хэрхэн хүндрэх аюултай вэ?
1. Хоолой боогдож бачуурах
 2. Хүчилтөрөгчийн дутагдлаас тархи хавагнаж, татах
 3. Уушгины хатгаагаар хүндрэх
 4. Уушги хийжих
 5. Гялтангийн хөндийд шингэн хуримтлагдах
- /5./ Хүүхдэд улаанбурханы ямар шинжүүдийг ажиглах ёстой вэ?
1. Түгээмэл тууралт
 2. Ханиалга.
 3. Нус гойжих
 4. Нүд улайх
 5. Халуурах.
- /6./ Тэмбүү өвчин эмэгтэйд ямар шинжүүдээр илэрч болох вэ?
1. Бэлэг эрхтний орчим шарх гарна
 2. Цавины булчирхай томорно
 3. Хэрвээ эмэгтэй жирэмсэн бол зулбах, дутуу төрөх, амьгүй хүүхэд төрөх хүндрэл тохиолдоно
 4. Үтрээнээс ээдэм төст ялгадас гарах
 5. Бэлэг эрхтэн их загатнах
- /7./ Жирэмсэн эхийг бэлгийн замын халдвараас сэргийлэхийн тулд ямар зөвлөгөө өгөх вэ?
1. Бэлгийн замын халдвараас ураг халдвар авах магадлал өндөр байдаг. Халдварласан ураг өвчтэй төрөх, гаж хөгжилтэй төрөх, бие султай болох магадлал ихтэй
 2. Бэлгийн замын халдвараас сэргийлэхийн тулд жирэмсэн эх өдөр бүр угаалга хийж, дотуур өмдөө сольж байх хэрэгтэй
 3. Бэлгийн замын халдвараас сэргийлэхийн тулд жирэмсэн эх бэлгийн нэг эрүүл хавьтагчтай байх, эсвэл бэлгэвч хэргэлдэг байх ёстой.
 4. Бэлгийн замын халдвараас сэргийлэхийн тулд жирэмсэн эх Метрогель тариулах хэрэгтэй.
 5. Бэлгийн замын халдвараас сэргийлэхийн тулд жирэмсэн эх Полижинакс гэдэг үтрээний лааг хэрэглэх ёстой
- /8./ Амьсгаадалт илэрсэн өвчтөнд бага эмч ямар тусламж үзүүлэх вэ?
1. Шалтгааныг яаралтай тогтооно
 2. Шалтгааны эсрэг ба эмгэг жамын гараа эмчилгээ хийнэ
 3. Тайвшруулна
 4. Хүчилтөрөгч өгнө эсвэл агаарын хангамжийг сайжруулна
 5. Эмнэлэгт хүргэж өгнө
- /9./ ХӨЦМ-ийн дагуу “Уушгины хатгалгаа” гэдэг ангилалтай 1-5 насны хүүхдэд бага эмч гэрээр ямар эм хэрэглэх вэ?
1. 1-р сонголтонд котримоксазолын 480 мг-ын шахмалаас бүтнээр 12 цагаар 5 хоног уулгана.
 2. 2-р сонголтонд Амоксациллины сироп 10 мл 250 мг-аар өдөрт 3 удаа 5 хоног уулгана
 3. Читамон хоногт 3 удаа уулгана

4. 1-р сонголтонд котримоксазолын 480 мг-ын шахмалаас талаар 12 цагаар 5 хоног уулгана.

5. 2-р сонголтонд Амоксациллины сироп 5 мл 125 мг-аар өдөрт 3 удаа 5 хоног уулгана.

/10./ Архинд согтож сэтгэл хөдөлгөөний догширол үүссэн өвчтөнийг бага эмч хэрхэн номхотгох вэ?

1. 2,5%-ын аминазины уусмалаас 2-4 мл эсвэл 2,5%-ийн тизерцины уусмалыг 2-4 мл эсвэл 0,5% галоперидолын уусмалыг 1-2 мл булчинд тарина

2. Эсвэл 1%-ийн димедролын уусмалаас 2-3 мл булчинд тарина

3. Эсвэл 0,5%-ийн седуксены уусмалаас 2-4 мл-г булчинд тарина

4. Эсвэл хлоралгидратаар бургуй тавина

5. Дээрхи эмүүдийн аль нэгийг хэрэглэхдээ 1-2 мл кордиаминтай хамт булчинд тарина.

/11./ 6 сартай 8 кг жинтэй хүүхэд 2 хоног суулгасан зовиуртай, үзлэгээр хүүхэд тайван бус, цочромтгой, ам нь цангасан, ховдоглон ууж байв. Хүүхдийн нүд хонхойсон, арьсны хуниас хурдан арилж байсан. Хүүхдийг үнэлж, ангилж, эмчил.

1. Хүнд шингэн алдсан гэж ангилаад хураагуур судсанд шингэн юүлнэ.

2. Шингэн алдсан гэж ангилаад 4 цагийн дотор 600 мл ШСД уусмал бага багаар уулгана

3. Шингэн алдсан гэж ангилаад 1200 мл ШСД уусмал аягаар бага багаар 4 цагийн турш уулга

4. Хүүхдийг хүссэн цагт нь хөхүүлнэ

5. Хүнд шингэн алдсан гэж ангилаад суулгалт бүрийн дараа 200 мл шингэн уулгана.

/12./ Халуурах шинж уушгины хатгалгааны шалтгаантайг ямар шинжээр батлах вэ?

1. Амьсгал олшрох

2. Ханиалгах, цэр гарах

3. Уушги тогшиход авиа бүдгэрэх, чагнахад амьсгал ширүүсэх, сулрах, нойтон хэрчигнүүр сонсогдох голомтот өөрчлөлт илрэх

4. Амьсгал гаргахад саадтай буюу шуугиантай

5. Амьсгал авахад саадтай буюу шуугиантай

/13./ Цээжээр өвдөх нь уушги, гялтангийн үрэвсэлтэй холбоотой байж болзошгүй бол ямар шинжүүдээр батлах вэ?

1. Амьсгалын хөдөлгөөнтэй холбоотой өвдөж, гүн амьсгалах, ханиах, найтаахад ихсэх

2. Өдвөлт зүүн гар, мөр рүү дамжих

3. Ханиах ба амьсгал олшрох, уушги чагнахад амьсгал сулрах, тогшиход авиа бүдгэрэх шинжүүд илрэх

4. Өдвөлт баруун гар, мөр рүү дамжих

5. Хөхийг тэмтрэхэд хөхний зангилаа хүчтэй өвдөх

/14./ “Халууралт. Нүд буюу амны хүндрэлтэй улаанбурхан” ангиллыг ямар шинжүүдээр тавих вэ?

1. Одоо буюу сүүлийн 3 сарын дотор улаан бурханаар өвчилсөн, халуунтай хүүхдийн нүднээс нуух гойжих

2. Нүдний эвэрлэг бүдгэрэх

3. Одоо буюу сүүлийн 3 сарын дотор улаан бурхнаар өвчилсөн, халуунтай хүүхдийн ам шархлаатай болох

4. Халуурч татсан

5. Халуурч, дагзны булчин хөшингө болсон

/15./ ХӨЦМ-ийн дагуу “Уушгины хатгалгаа” гэдэг ангилалтай 2 сараас 1 хүртлэх насны хүүхдэд бага эмч гэрээр ямар эм хэрэглэх вэ?

1. 1-р сонголтонд котримоксазолын 480 мг-ын шахмалаас талаар 12 цагаар 5 хоног уулгана

2. 2-р сонголтонд Амоксациллины сироп 5 мл 125 мг-аар өдөрт 3 удаа 5 хоног уулгана

3. Читамон хоногт 3 удаа уулгана

4. Гентомицин 40 мг-аар 12 цагаар 5 хоног тарина

5. Кодеин тал шахмалаар уулгана

/16./ 20 долоо хоногтой жирэмсэн эхийн үзлэгээр юу хийх ёстой вэ?

1. Эрүүл мэндийн талаар асуумж авах

2. Эх барихын тусгайлан үзлэг хийх

3. Биеийн үзлэг хийх
 4. Ургийн байрлал, түрүүлсэн хэсгийг тогтоох
 5. Ургийн зүрхний цохилтыг сонсох
- /17./ Бэлгэвч хэрэглэхийг хориглох заалт юу вэ?
1. Жирэмсэн
 2. Шалтгаан тодорхой бус үтрээний цус алдалт
 3. Үтрээ, умайн хүзүүн үрэвсэл, шарх, бэлгийн замын халдвар
 4. Резинд харшилтай
 5. Хүнд хэлбэрийн цус багадалт
- /18./ В вируст гепатитаас урьдчилан сэргийлэх зорилгоор бага эмч ямар арга хэмжээнүүдийг авсан байх ёстой вэ?
1. Нярайд 24-48 цагийн дотор, мөн 2,8 сартай хүүхдийг В гепатитын эсрэг өвөрмөц дархлаажуулалтанд хамруулна
 2. Өвчлөгсдийг эрт илрүүлэх
 3. Доноруудыг шинжлэх
 4. Нэг удаагийн тариур, багаж хэрэгсэл ашиглах
 5. Бээлий, хөдөлмөр хамгааллын хувцас ашиглах
- /19./ Хүүхдийн түвэнхийн үрэвсэл, нарийсал ямар шинжүүдээр илэрдэг вэ?
1. Хяхтнаа амьсгал
 2. Хоолой сөөх
 3. Хуцуулах ханад
 4. Шуугиант амьсгал
 5. Хөхүүлэх ханиад
- /20./ Төрөхөд вакцинуудаа хийлгээгүй 14 хоногтой хүүхдэд ямар вакцинуудыг нөхөн хийж болох вэ?
1. БЦЖ
 2. Саа-1
 3. ВГ-1
 4. 5-т вакцин
 5. СХХТ
- /21./ Толгой өвдөх шинж ямар эмгэгүүдмйн үед тохиолдох вэ?
1. Гавлын дотоод даралт ихсэх эмэгэгүүд /Тархины хавдар, харвалт, буглаа/
 2. Цусны даралт ихсэх буюу багасах, цусны сахар багасах
 3. Хордлого ихтэй халдварт өвчнүүд, нүд, шүд, чих, хамар хоолойн өвчин
 4. Тархи доргих, гэмтэх, толгойн ил, далд гэмтэл, наранд цохиулах
 5. Сэтгэцийн шалтгаантай стресс, мигрень
- /22./ Депо-проверагийн сул тал юу вэ?
1. Толгой өвдөх, хөхөөр хөндүүрлэх гаж нөлөө илэрч болно
 2. Биений юмгүйдэл эсвэл биеийн юмны хооронд цусархаг ялгадас гарч болно.
 3. Биеийн жин бага зэрэг нэмэгдэж болно
 4. Үс унах, нүүрэнд батга гарах, бэлгийн дуршил буурах гаж нөлөө илэрч болно
 5. Бэлгийн замын халдвараас хамгаалахгүй
- /23./ Элэгний буюу паренхиматозны шарлалт ямар шалтгаантай үүсдэг вэ?
1. А, В, С, Д, Е вирус гепатит
 2. Үжил, хумхаа, хорт цус багадалт, туяаны өвчин
 3. Элэгний өмөн, лептоспироз, моноклеоз, архаг гепатит
 4. Цөс чулуужих өвчин, цөсний ерөнхий цоргоны нарийсал
 5. Нойр булчирхайн толгойн хавдар
- /24./ Гуурсан хоолойн үрэвслийн үед ямар эмчилгээ хийх вэ?
1. Үрэвслийн эсрэг
 2. Гуурсан хоолойн агчилтыг тавиулах
 3. Цэр ховхлох, шингэлэх эмийн эмчилгээ
 4. Гуурсан хоолойг өргөсгөх
 5. Утлага

/25./ Жирэмсний хожуу үеийн хордлогын шинж илрэхэд эх яагад эмчид даруй үзүүлэх ёстой вэ?

1. Эхэс хавагнах, ураг бүтэх магадлал ихтэй
2. Эх манас таталтаар хүндрэх магадлал ихтэй
3. Эх амь насаа алдах аюултай
4. Төрөлхийн гажигтай хүүхэд төрөх магадлал өндөр
5. Хөлний хаван насан туршдаа тогтох магадлал өндөр

/26./ Мөөгөнцөрийн халдвар ямар шинжээр илэрдэг вэ?

1. Үтрээнээс ээдэм төст ялгадас гарах
2. Хавьтагчийн шээсний сүвнээс идээ гарч байсан
3. Бэлэг эрхтэн их загатнах
4. Үтрээнээс идээрхэг, хэвийн бус ялгадас гарах
5. Хавьтагч шээхэд хорсож байсан

/27./ Өвчтөний амьсгаадалт ларингитаас шалтгаалж буйг ямар шинжүүдээр батлах вэ?

1. Хяхтанаж амьсгалах буюу амьсгал авах үедээ саадтай буюу шуугиантай
2. Хоолой сөөх
3. Хуцуулж ханиах
4. Амьсгал гаргах үедээ саадтай буюу шуугиантай
5. Хөхүүлж ханиах

/28./ ХӨЦМ-ийн дагуу “Уушгины хүнд хатгалгаа” гэдэг ангилалтай хүүхдэд бага эмч ямар тусламж үзүүлэх вэ?

1. Гараа эмчилгээнд үүсгэгчийн эсрэг эмийн эхний тунг өгнө
2. Гараа эмчилгээнд цусны сахар багсахаас сэргийлнэ
3. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
4. Үүсгэгчийн эсрэг эм 5 хоног уулгаад гэрээр эмчилнэ
5. Хоргүй зөөлөн эмээр ханиалгыг эмчлэнэ

/29./ Сэтгэл гутралтай өвчтөнг ямар тохиолдолд эмнэлэгт хэвтүүлэх заалттай вэ?

1. Амиа хорлох буюу үхэх бодолтой
2. Амиа хорлох тусгай төлөвлөгөөтэй
3. Өнгөрсөн хугацаанд амиа хорлох ноцтой оролдлого хийж байсан
4. Бусдын амь насанд хор хохирол учруулах бодолтой
5. Хүнд хэлбэрийн сэтгэл гутрал

/30./ 20 долоо хоногтой жирэмсэн эхийн үзлэг хийх зорилго нь юу вэ?

1. Жирэмсний хугацааг тодорхойлох
2. Ургийн өсөлт, хөгжлийг үнэлэх
3. Жирэмснийг тээлгэх эсэх асуудлыг шийдвэрлэх.
4. Жирэмсний явц, эмгэг байдлыг үнэлэх
5. Төрөх газрыг товлох

/31./ Бэлгэвч хэрэглэхийн сул тал юу вэ?

1. Резинд харшил үүсч болно
2. Бэлгийн хавьтлын үед бэлгэвч мултрах, урагдах эрсдэлтэй
3. Бэлгийн дур буурч болно
4. Бага аарцгийн үүрэвсэл үүсгэж болзошгүй
5. Үргүйдэл, умайн гаднах жирэмслэлт үүсч болзошгүй

/32./ Халуурах шинж амьсгалын тогтолцооны ямар өвчний үед илэрдэг вэ?

1. Гүйлсэн булчирхайн цочмог үрэвсэл
2. Гуурсан хоолойн цочмог үрэвсэл
3. Түвэнх хоолойн цочмог үрэвсэл
4. Уушгины хатгалгаа
5. Уушгины гялтангийн идээт үрэвсэл

/33./ Хяхтнаа амьсгал ямар эмгэгийн үед сонсогдох вэ?

1. Төвөнхийн үрэвсэл, нарийсал
2. Уушгины үрэвсэл
3. Түвэнх хоолой дээр гадны биет торох
4. Мөгөөрсөн хоолойн үрэвсэл

5. Гуурсан хоолойн үрэвсэл
- /34./ Вакцины гаж нөлөө болон хүндрэл ямар байдлаар илрэх вэ?
1. Хэсэг газрын урвал (улайх, хавдах, буглах)
 2. Ерөнхий урвал (халуурах, хордлогын хам шинж)
 3. Дотор эрхтэнд халдвар харшлын хүндэрлүүд (бөөрний, зүрхний булчингийн үрэвсэл)
 4. Архаг харшлын өвчин сэдрэх (багтраа, арьсны өвчнүүд)
 5. Мэдэрлийн тогтолцооны эмгэг сэдэрснээс татах
- /35./ Депо-проверагийн ашигтай тал юу вэ?
1. 3 сарын турш жирэмслэлтээс хамгаална
 2. Бэлгийн хавьталд саад учруулахгүй
 3. Хөх, умай, өндгөвчний хорт хавдар, цус багадалтаас сэргийлнэ
 4. Бэлгийн замын халдвараас сэргийлнэ
 5. Эмэгтэй таргалахаас айхгүй
- /36./ Элэгнээс дээш буюу цус задарлын /гемолитик/ шарлалт ямар шалтгаантай үүсдэг вэ?
1. А, В, С, Д, Е вирус гепатит
 2. Үжил, хумха
 3. Цөс чулуужих өвчин, цөсний ерөнхий цоргоны нарийсал
 4. Хорт цус багадалт, туяаны өвчин
 5. Нойр булчирхайн толгойн хавдар
- /37./ Бөөрний архаг дутагдлын үед илрэх шинжүүдийг нэрлэнэ үү?
1. Арьсны өнгө зэвхий саарал
 2. Шээсний хувийн жин буурна
 3. Цусанд креатинин ихсэнэ
 4. Ханиалгаж цэр гарах
 5. Гар хөл салгалж чичрэнэ
- /38./ “Хүнд хүндрэл бүхий улаанбурханыг” ямар шинжүүдээр ангилах вэ?
1. Татах
 2. Нүдний эвэрлэг бүдгэрэх
 3. Амны гүнзгий өргөн шархлаа
 4. Амьсгал олшрох
 5. Суулгах
- /39./ Заг хүйтний эмчилгээнд юуг хэрэглэх вэ?
1. Бензатилпенициллин G 2,6 саяаар тарина
 2. Циплофлоксацин 500 мг нэг удаа уух
 3. Доксацилин 100 мг-аар өдөрт 2 удаа 7 хоног уух эсвэл Эритромицин 500 мг-аар өдөрт 4 удаа уух.
 4. Цефтриаксон 250 мг булчинд нэг удаа тарих
 5. Метронидазол 2 гр нэг удаа уулгах эсвэл Метронидазол 400-500 мг өдөрт 2 удаа 7 хоног уух.
- /40./ Зүрхний дутагдлаас үүсэж буй амьсгаадалтын үед ямар эмчилгээ чухал вэ?
1. Дигоксин эсвэл коргликон
 2. Панангин эсвэл калийн хлорид
 3. Фуросемид эсвэл диакарб
 4. Эуфиллин
 5. Антибиотик
- /41./ Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын үйлчлүүлэгчдэд зонхилон тохиолддог сэтгэцийн эмгэгүүд:
1. Сэтгэл гутрал
 2. Сэтгэл түгших эмгэгүүд
 3. Архи хэрэглэх эмгэгүүд
 4. Нойрны хямарлууд
 5. Архаг ядаргаа
- /42./ 12 долоо хоногтой жирэмсэн эмэгтэйд анхны үзлэгээр ямар шинжилгээ хийх ёстой вэ?
1. Цус, шээсний ерөнхий шинжилгээ
 2. Чанд авианы шинжилгээ

3. Үтрээний наацын шинжилгээ
4. Тэмбүү, ХДХВ-ийн шинжилгээ
5. Флюорографи

/43./ Гепатитын шарлалтын өмнөх үед илэрч болзошгүй ямар шинжүүдийг өрхийн эмч мэддэг байх ёстой вэ?

1. Хоолонд дургүй болох, дотор муухайрах, бөөлжих, суулгах
2. Халуурах, толгой өвдөх, ханиах, хамар битүүрэх
3. Ядарч сульдах, түрүүлгээ харж хэвтэх
4. Цэгчилсэн цусан тууралт хөлний шагай орчим гарах
5. Мэнэн төст шинжүүд илрэх

/44./ Халуурах шинж ямар өвчний үед илэрдэг вэ?

1. Томуу, иж томуу, амьсгалын замын вирус, нянгаар үүсгэгдсэн цочмог үрэвслүүд
2. Гэдэсний халдварт өвчнүүд
3. Бөөр, шээсний замын цочмог үрэвслүүд
4. Хэрх өвчин, хэрх төст өвчин, ёлом
5. Мэнэн, хүүхдийн цочмог халдварт өвчнүүд /улаан бурхан, улаан эсэргэнэ, гахайн

хавдар, салхин цэцэг

/45./ Цус алдалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор окситоцин тарих хугацаа, арга

1. Ургийн толгой төрөх үед судсанд 0.9% натри хлоридоор шингэлж
2. Тулгар төрөгчид толгой цухуйх үед дуслаар урсгаж хийнэ
3. Давтан төрөгчид толгой цухалзах үеэс дуслын тоогоо нэмж урсгаж хийнэ
4. Хүүхэд төрсний дараа хийнэ
5. Төрөлтийн I үеийн идэвхтэй шатанд

/46./ Тээвэрлэх болон гэрийн төрөлтийн үеийн яаралтай тусламжинд ямар хэрэгслүүд зайлшгүй шаардлагатай вэ?

1. Судасны катетер ба систем
2. Бээлий, шээлгүүр
3. Ариун тариур, зүү, үжилгүйжүүлэх уусмал
4. Хурц зүслийн сав, хог хийх уут
5. Гар чийдэн, нөөц зай

/47./ Жирэмснээс хамгаалах депо-провераг хэдийд, яаж хэрэглэх вэ?

1. Биений юм ирсэн 3 дахь өдөр
2. 12 долоо хоног буюу 3 сар тутам
3. Биений юм ирсэн 5 дахь өдрөөс эхлэн өдөр бүр нэг шахмалыг ууна
4. 3 сар тутам нэг удаа бульчинд тарина
5. Бэлгийн хавьталд орохын өмнө тогтмол

/48./ Шарлах шинж ямар шалтгаантай үүсэх вэ?

1. А, В, С, Д, Е вируст гепатит
2. Элэгний өмөн, лептоспироз, моноклеоз, архаг гепатит
3. Үжил, хумхаа, хорт цус багадалт, туяаны өвчин
4. Цөс чулуужих өвчин, цөсний ерөнхий цоргоны нарийсал
5. Нойр булчирхайн толгойн хавдар

/49./ Жирэмсний хожуу үеийн хордлого ямар шинжээр илэрдэг тухай эхэд ямар мэдээллийг өгөх вэ?

1. Жирэмсний жин долоо хоногт 350-400 граас илүү ихээр нэмэгдэх
2. 2 хөл, биеэр хавагнах
3. Шээсний гарц багасах
4. Толгой өвдөх, артерийн даралт ихсэх
5. Шээсэнд уураг ялгарах

/50./ “Халууралт” гэж ангилалдсан, өөр ангилалгүй хүүхдэд ямар тусламж үзүүлэх вэ?

1. 38,5 хэмээс дээш халуунтай бол парацетамол өгнө
2. Хэзээ яаралтай эргэж үзүүлэхийг эхэд зөвлөнө
3. Халууралт намжихгүй бол 2 хоноод давтан үзүүлэхийг зөвлөнө
4. Үүсгэгчийн эсрэг эм 5 хоног өгнө.
5. Хордлого тайлах дусал хийнэ

/51./ Трихомоназын эмчилгээнд юуг хэрэглэх вэ?

1. Бензатилпенициллин G 2,6 саяаар тарина
2. Циплофлоксацин 500 мг нэг удаа уух
3. Доксациклин 100 мг-аар өдөрт 2 удаа 7 хоног уух эсвэл Эритромицин 500 мг-аар өдөрт 4 удаа уух.
4. Метронидазол 2 гр нэг удаа уулгах эсвэл Метронидазол 400-500 мг өдөрт 2 удаа 7 хоног уух
5. Цефтриаксон 250 мг булчинд нэг удаа тарих

/52./ ХӨЦМ-ийн дагуу “Уушгины хатгалгаа” гэдэг ангилалтай хүүхдэд бага эмч ямар тусламж үзүүлэх вэ?

1. Уушгины хатгалгааг гэрээр эмчлэхийг зөвлөнө
 2. Үүсгэгчийн эсрэг эмийг 5 хоног уулгана
 3. Хоргүй зөөлөн эмээр ханиалгыг эмчлэнэ
 4. Хэзээ яаралтай эргэж үзүүлэхийг зөвлөнө
 5. 2 хоноод давтан үзлэг товлон
- /53./ Сэтгэл түгших эмгэгтэй өвчтөнд өрхийн эмчийн зүгээс хийх эмчилгээ:
1. Зөвлөгөөг сайн өгөхөд эмийн эмчилгээ бараг шаардлагагүй байдаг
 2. Хүнд хэлбэрийн сэтгэл түгшилттэй өвчтөнд седуксеныг 5-10 мг-аар орой унтахын өмнө 2 долоо хоногоос илүүгүй хугацаагаар хэрэглэнэ
 3. Сэтгэл түгших эмгэг гутрах эмгэгтэй хавсарсан тохиолдолд амитриптиллиныг орой унтахын өмнө уулгана
 4. Аминазин уухаар хэрэглэнэ
 5. Димедрол уулгана

/54./ ЭМСайдын тушаалын дагуу анхны үзлэгээр өвчтэй нь тогтоогдсон жирэмсэн эмэгтэйд хэн хянах ёстой вэ?

1. Эх барих эмэгтэйчүүдийн эмч
2. Сумын эмч
3. Нарийн мэргэжлийн эмч тухайн өвчнөөс нь хамааран
4. Багийн бага эмч
5. ЭНЭШТ-ийн эмч

/55./ Бэлгэвч хэрэглэх ашигтай тал юу вэ?

1. Бэлгийн замын халдвараас хамгаална
2. Аль ч насны эмэгтэйд тохиромжтой
3. Хөхний сүүний гарц, чанарт нөлөөлөхгүй
4. Жирэмсэн үед мөн төрөлт, зулбалт, үр хөндөлтийн дараа шууд хэрэглэх боломжтой
5. Хүссэн үедээ хэрэглэх, зогсоох боломжтой

/56./ Тунгалгийн булчирхай цочирдог өвчнүүдийг дурьдна уу.

1. тарваган тахал
2. бруцеллёз
3. елом
4. вирус гепатит
5. томуу

/57./ Хэвлийгээр өвдөх шинж илэрсэн өвчтөнд бага эмч ямар тусламж үйлчилгээ үзүүлэх вэ?

1. Мухар олгойн үрэвсэл, гэдэсний түгжрэл, умайн гаднах жирэмслэлт, хэвлийн гялтангийн үрэвсэл байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд эмнэлэгт яаралтай хүргэж өгнө
2. Элэгний цочмог халдварт үрэвсэл хэвлийгээр өвдөх шалтгаан болж байвал антибиотик уулгаж, ходоод угааж, цэвэрлэх бургуй тавина.
3. Нарийн, бүдүүн гэдэсний халдварт өвчин хэвлийгээр өвдөх шалтгаан болж байвал үүсгэгчийн эсрэг эм өгнө, шингэн алдалтаас сэргийлнэ
4. Ходоодны архаг үрэвсэл хэвлийгээр өвдөх шалтгаан болж байвал Контрикал судсаар дуслаар хийж эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
5. Давсаг, шээлүүрийн үрэвсэл хэвлийгээр өвдөх шалтгаан болж байвал хэвлийд хүйтэн жин тавьж, мөс хөлхүүлэх

/58./ Төрөх хугацааг олохдоо:

1. Ураг анх хөдөлсөн өдөр дээр тулгар төрөгчид 20 долоо хоногийг нэмнэ

2. Овуляци болсон өдөр дээр 42 долоо хоногийг нэмнэ
 3. ССТ ирсэн сарыг 3–р урагшлуулж эхний өдөр дээр 7-г нэмнэ
 4. Ураг анх хөдөлсөн өдөр дээр давтан төрөгчид 20 долоо хоногийг нэмнэ
 5. Үзлэгээр хүйсний хонхор тэгширсэн
- /59./ Вакцин хийлгэсэн хүүхдийн ээжид юуг сануулах ёстой вэ?
1. Хүүхэд нэг өдөр бие нь тавгүй болж, халуурч болзошгүй
 2. Энэ нь вакцинд дархлаа үүсэж буй хэвийн хариу урвал тул айх хэрэггүй, хүүхдээ сайн хөхүүлж, шингэн сайн уулга
 3. Хэрэв хүүхэд нэгээс олон хоног халуурвал, хатгалт орчмын арьс улайж, хавдвал авчирч үзүүлэх хэрэгтэй
 4. Хэрэв хүүхэд вакцин хийлгэсэн өдрөө халуурвал котримоксазол, парацетамол хоёрыг өгөөрэй.
 5. Вакцин хийсэн өдөр хүүхэд халуураагүй ч гэсэн өвдөлт намдаах зорилгоор парацетамол уулгах хэрэгтэй
- /60./ Физиологийн гаралтай биений юмгүйдэл хэзээ ажигладдаг вэ?
1. Хүүхэд насанд
 2. Жирэмсэн үед
 3. Цэвэршсэн эмэгтэйд
 4. Хөхүүл байх бүх хугацаанд
 5. Төрсний дараа 2 жил
- /61./ Ураг дутагдлын хавантай өвчтөнд ямар эмчилгээ хамгийн чухал вэ?
1. Альбумин эсвэл плазм
 2. Дигоксин эсвэл коргликон
 3. Уураглаг хоол эмчилгээ
 4. Панангин эсвэл калийн хлорид
 5. Гепарин
- /62./ Элэгний вирүсийн үржлийг саатуулдаг эмийг олно уу?
1. Эссенциал
 2. Интерферон
 3. Карсил
 4. Ламивудин
 5. Витамины комплекс
- /63./ 38 долоо хоногтой жирэмсэн эхэд ямар зөвлөгөө өгөх ёстой вэ?
1. Төрөлтөнд бэлтгэх тухай
 2. Төрөх үеийн өвдөлт бууруулах аргуудын тухай
 3. Илүү тээлтийн тухай
 4. Төрсний дараах үеийн тухай
 5. Төрөх үйл ажиллагааны тухай
- /64./ “Маш хүнд халууралт өвчин” гэж ангилагдсан хүүхдэд ямар тусламж үзүүлэх вэ?
1. Эмнэлэгт хэвтүүлэх шаардлагатайг эхэд нь ойлгуулна
 2. Үүсгэгчийн эсрэг тохирох эмийн эхний тунг өгнө
 3. Цусны сахар багасахаас сэргийлж эмчилнэ
 4. 38,5 хэмээс дээш халуунтай бол парацетамол өгнө
 5. Гараа эмчилгээ хийсний дараа эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
- /65./ “Заг хүйтэн эсвэл хламидийн халдвар байж болзошгүй” гэсэн ангилал бүхий эмэгтэйд бага эмч ямар тусламж үзүүлэх вэ?
1. Тохирох антибиотیکیг эмэгтэйд уулгана
 2. Тохирох антибиотیکیг хавьтагчид уулгана
 3. Бэлгэвчийг зөв, байнга хэрэглэх талаар зөвлөгөө өгнө
 4. Дахин бэлгийн хавьталд орохгүй байхыг зөвлөнө
 5. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
- /66./ Амьсгалын тогтолцооны ямар эмгэгийн үед амьсгаадах шинж илэрдэг вэ?
1. Гуурсан хоолойн бөглөрөлт үрэвсэл, уушгины цочмог хатгалгаа
 2. Түвэнх хоолойн үрэвсэл, бачуурал. Багтраа
 3. Уушгины архаг үрэвсэл буюу пневмоклероз. Уушги тоосжих өвчин буюу пневмокониоз

4. Уушгины ба гялтангийн хавдар
 5. Уушгины шүүдэст плеврит, пневмоторокс
- /67./ ХӨЦМ-ийн дагуу “Уушгины хатгалгаа” гэдэг ангилалтай хүүхдийг бага эмч гэрээр эмчлэхдээ ямар шинж илэрвэл яаралтай ирж үзүүлэхийг зөвлөх вэ?
1. Уух буюу хөхөндөө муудах
 2. Өвчин хүндрэх
 3. Халуурах
 4. Амьсгал олшрох
 5. Уйлагнах
- /68./ Сэтгэл түгших эмгэгтэй өвчтөнд бага эмчийн зүгээс өгөх зөвлөмжүүд:
1. Стресс тайлах ур чадварыг эзэмших зөвлөгөө өгнө
 2. Сэтгэл түгших эмгэг бол эмчлэгдэх боломжтой өвчин гэдгийг ойлгуулна
 3. Зүрх дэлсэх, амьсгал давчих зэрэг биеийн шинжүүдэд анхаарлаа төвлөрүүлэхгүй байх, учир нь айдас, түгшэлтийг улам ихэсгэдэг гэдгийг ойлгуулах
 4. Өөрийгөө тайвшруулан удирдах ба амьсгалын дасгал хийж сурах
 5. Сэтгэл түгшилт, айдасыг даван туулахын тулд архи хэрэглэхээс зайлсхийх
- /69./ Жирэмснээс хамгаалах дан прогестерон агуулсан эмийг хэрэглэхийг хориглох заалт юу вэ?
1. Жирэмсэн
 2. Тамхи татдаг эмэгтэй
 3. Элэгний эмгэг ба хөхний хорт хавдар
 4. Зүрхний цус хомсдох эмгэгтэй
 5. Цусны даралт ихтэй ба цус өтгөрөх эмгэгтэй
- /70./ Тууралт үндсэн шинж нь болдог өвчнүүдийг дурьд:
1. Сахуу
 2. Улаан бурхан
 3. Татран
 4. Улаан эсэргэнэ
 5. Хумхаа
- /71./ Гэдэс түгжрэх нь хэвлийгээр өвдөх шалтгаан болж байгааг ямар шинжүүдээр батлах вэ?
1. Хэвлий дүүрч, цардайж өвдөх
 2. Өтгөн, хийгээ гаргаж чадахгүй болох
 3. Хэвлийн тойм зурганд Клойбэрийн аяганууд илрэх
 4. Хараар баах
 5. Цусанд диастаза ихсэх.
- /72./ Вакцин хийхээс татгалзах эсрэг заалтууд:
1. ДОХ-той хүүхдэд БЦЖ хийхгүй
 2. СХХТ вакциныг ТМТ-ийн хүнд хурц эмгэгтэй хүүхдэд хийхгүй
 3. СХХТ вакцин хийлгээд 3 хоногийн дотор татсан ба цохиулалтанд орсон хүүхдэд давтан СХХТ хийхгүй.
 4. Өнөөдөр эмнэлэгт хэвтүүлэх заалттай хүнд өвчтэй хүүхдэд ямар ч вакцин хийхгүй.
 5. “Уушгины хүнд хатгалгаа” оношоор эмнэлэгт хэвтэх заалттай атлаа хэвтээгүй хүүхдэд вакцин хийхгүй
- /73./ “Хүндрэлтэй үр хөндөлт, зулбалт” гэдэг ангилалтай эмэгтэйд ямар тусламж үзүүлэх вэ?
1. Тохирох антибиотیکیг булчинд, судсанд тарина.
 2. Парацетамол өгч өдвөлтийг намдаана
 3. Судсаар дусал хийнэ. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
 4. Гэрт нь хариулна, 2 хоноод давтан үзүүлэхийг зөвлөнө.
 5. Умайд иллэг хийнэ.
- /74./ Жирэмсний магадгүй шинжүүд юу вэ?
1. Биений юм хоригдох
 2. Үтрээ болон умайн хүзүүний салст хөхрөх
 3. Хэвлийн цагаан шугам, хөхний толгой нөсөөтөх
 4. Ургийн хэсэг тэмтрэгдэх
 5. Огиулж бөөлжих

/75./ Чихрийн шижин өвчний үед илрэх шинжүүдийг нэрлэнэ үү?

1. Ам цангах
2. Их уух
3. Их шээх
4. Арьс цонхийж цайх
5. Нойронд муудах

/76./ 38 долоо хоногтой жирэмсэ эхийн үзлэгээр юу хийх ёстой вэ?

1. Эрүүл мэндийн талаар асуумж авах, биеийн үзлэг хийх
2. Ургийн байрлал, түрүүлсэн хэсэг, янзыг тодорхойлох
3. Ургийн зүрхний цохилтыг сонсох
4. Дотуур үзлэх хийх
5. Дотуур ЭХО хийх

/77./ “Маш хүнд халууралт өвчнийг” ямар шинжүүдээр ангилах вэ?

1. Хүүхэд халуунтай ба аюултай ерөнхий шинжийн аль нэг илрэх
2. Хүүхэд халуурч татах
3. Хүүхэд халуунтай ба хүзүү хөшингө болох
4. 40 хэмээс дээш халуурах
5. Халуурсан хүүхэд хоолонд дургүй болох

/78./ Амьсгаадах шинж ямар өвчин эмгэгийн үед илэрдэг вэ?

1. Зүрхний дутагдал, зүрхний шигдээс, үнхэлцгэнд шингэн хуримтлагдах, зүрхний гажиг
2. Хүнд хэлбэрийн хатгаа, багтраа, түвэнх хоолойн үрэвсэл, шүүдэст плеврит
3. Тархи нугасны хавдар, уушгины хавдар
4. Миоастений, булчин даамжран хатингарших эмгэг, өрцний мэдэрлийн саажилт
5. Хүнд хэлбэрийн цус багадалт

/79./ ХӨЦМ-ийн дагуу “Ханиад шуухнаа” гэдэг ангилалтай хүүхдийг бага эмч гэрээр эмчлэхдээ ямар шинж илэрвэл яаралтай ирж үзүүлэхийг зөвлөх вэ?

1. Уух буюу хөхөндөө муудах
2. Өвчин хүндрэх
3. Халуурах
4. Амьсгал олшрох
5. Амьсгал саадтай болох

/80./ ЭМСайдын тушаалаар 12 долоо хоногтой жирэмсэнд анхны үзлэгээр юу хийх ёстой вэ?

1. Эрүүл мэндийн талаар асуумж авах, биеийн үзлэг хийх
2. Эх барихын тусгайлан үзлэг хийх
3. Нарийн мэргэжлийн эмч нарт үзүүлэх
4. Ургийн байрлал, түрүүлсэн хэсгийг тогтоох
5. Ургийн зүрхний цохилтыг сонсох

/81./ Жирэмснээс хамгаалах дан прогестерон агуулсан эмийн сул тал юу вэ?

1. Дотор эвгүүрхэх, толгой өвдөх гаж нөлөө илэрч болно
2. Хөхөөр хөндүүрлэж болно
3. Биеийн жин бага зэрэг нэмэгдэж болно
4. Эмийг өдөр бүр уух нь төвөгтэй
5. Бэлгийн замын халдвараас хамгаалахгүй

/82./ Сүрьеэгийн сэжигтэй шинж тэмдэгийг нэрлэнэ үү.

1. 3 долоо хоногоос дээш хугацаагаар ханиах
2. Цустай цэр гаргах
3. Цээжээр өвдөх
4. Халуурах
5. Турах

/83./ Эх барихын тусгайлсан гадуур үзлэгээр юунаас бусдыг тодорхойлох вэ?

1. Хэвлийн эргэн тойрон
2. Умайн ёроолын өндөр
3. Ургийн байрлал, түрүүлсэн хэсэг
4. Умайн доод таславчийн байдал

5. Ургийн зүрхний цохилт
- /84./ Зүрхний дутагдлаас үүсэх хаванд ямар эмчилгээ хамгийн чухал вэ?
1. Дигоксин эсвэл коргликон
 2. Панангин эсвэл калийн хлорид
 3. Фуросемид эсвэл диакарб
 4. Эуфиллин
 5. Антибиотик
- /85./ “Заг хүйтэн эсвэл хламидийн халдвар байж болзошгүй” гэсэн ангилалыг ямар шинжийг үндэслэн тавих вэ?
1. Үтрээнээс идээрхэг, хэвийн бус ялгадас гарах
 2. Хавьтагчийн шээсний сүвнээс идээ гарч байсан
 3. Хавьтагч шээхэд хорсож байсан
 4. Үтрээнээс ээдэм төст ялгадас гарах
 5. Бэлэг эрхтэн дээр яр гарах
- /86./ Сэтгэл түгших үед өвчтөнд илэрч болох шинжүүд:
1. Зүрх дэлсэх, судасны цохилд олшрох, артерийн даралт ихсэх
 2. Амьсгал олшрох, амьсгаа давчдах, цээжин дээр хүнд юм дарах мэт санагдах
 3. Ходоод орчим өвдөх, агших нь мэдэгдэх, юм залгихад түвэгтэй мэт санагдах
 4. Шээс ойр ойрхон хүрэх
 5. Нойр хульжих
- /87./ ЭМСайдын тушаалаар хэвийн явцтай жирэмсэнг жирэмсний хугацаанд эмзэг байдал илрээгүй бол бага эмч хэдэн удаа заавал үзсэн байх шаардлагатай вэ?
1. 2-3 удаа
 2. 3-4 удаа
 3. 4 удаа
 4. 6 удаа
 5. 8 удаа
- /88./ Умайн гадуурх жирэмслэлт хэвлийгээр өвдөх шалтгаан болж байгааг ямар шинжүүдээр батлах вэ?
1. Хэвлийн доод хэсгээр өвдөнө
 2. Үтрээнээс хар хүрэн цусархаг ялгадас гарна
 3. Үтрээний арын хүнхрээний хатгалт хийхэд цус сорогдоно
 4. Цустай баана
 5. Ургийн хэсгүүд тэмтрэгдэнэ
- /89./ Жирэмсэн эмэгтэйд үзлэгээр дараах зүйлүүдийг заавал үзэж тэмдэглэнэ.
1. Артерийн даралтыг 2 гарт
 2. Биеийн жинг нимгэн хувцастай үзэх
 3. Өндөр
 4. Судасны цохилт
 5. Амьсгалын тоо
- /90./ Ампициллин, Гентомицин, Метронидазол зэрэг Зантибиотикийг эмэгтэйд ямар заалтаар зэрэг хэрэглэдэг вэ?
1. Хэвлийгээр хүчтэй өвдөх эсвэл маш хүнд халууралт өвчнүүд
 2. Хүндрэлтэй зулбалт, үр хөндөлт
 3. Умайн болон ургийн халдвар
 4. Төрсний дараах цус алдалт 24-өөс дээш цаг үргэлжилсэн эсвэл төрснөөс хойш 24 цагийн дараа цус алдсан
 5. Шээсний дээд замын өвчин
- /91./ Вируст гепатитаар өвчлөөд эдгэрсэн өвчтөнд нөхөн сэргээх шатанд нь бага эмч ямар тусламж үзүүлэх вэ?
1. Нэг жилийн турш хяналтанд байлгана
 2. Алат, Асат, билирубины шинжилгээг 3–6 сар тутамд давтан үзнэ
 3. Өөх тосгүй, шарж хуурайгүй, хурц амтлагчгүй хоол идэхийг зөвлөнө
 4. Архи, пив, шоколад зэргийг хатуу хорино

5. Биеийн хүнд хүчир ажил, тэмцээнд оролцохгүй байх ба шөнө 8-аас доошгүй цаг, өдөр нэг цаг унтаж амарч байхыг зөвлөнө

/92./ Ямар тохиолдолд толгой маш хүчтэй өвддөг вэ?

1. Мэнэн, тархи устгах
2. Цусны даралт гэнэт ихсэх
3. Тархинд их хэмжээний цус хурах
4. Нүдний даралт ихсэх
5. Тархины хавдар

/93./ Жирэмсэн эх жирэмсний хожуу хордлогоос сэргийлэхийн тулд ямар арга хэмжээ авахыг эхэд зөвлөх вэ?

1. Уух шингэнийг хоногт 700-800 мл хүртэл хязгаарлах
 2. Давсны хэмжээг 3-5 гр хүртэл хязгаарлах
 3. Цагаан идээ, ургамлын гаралтай аминдэмээр баялаг хоол идэх . Долоо хоногт 1 өдөр цагаан хоол эсвэл 1-1,5 кг алим идэх
 4. Биеийн жингээ тогтмол үзүүлж, эмгэг нэмэгдэл байгаа эсэхийг тогтоолгох
 5. Артерийн даралтаа хэмжүүлж байх. Хөлөнд хаван үүсч буй эсэхийг ажиглаж байх.
- Шээсний шинжилгээ өгөх

/94./ Тээвэрлэх болон гэрийн төрөлтийн үеийн яаралтай тусламжинд ямар эмүүд зайлшгүй шаардлагатай вэ?

1. Окситоцин, эргометрин
2. Магнийн сульфат, диазепам
3. Кальцийн глюконат
4. Ампициллин, Гентамицин, Метронидазол
5. Рингенийн лактат

/95./ Цус алдах хам шинж ямар шалтгаанаар үүсдэг вэ?

1. Гемофили буюу төрөлхийн цус гойжимтгой эмзэгшил
2. Тромбоцитопени буюу тромбоцитопати
3. Васкулит буюу судасны үрэвсэл
4. Судасны хана гэмтэх
5. Ходоодны шарх задрах

/96./ Улаан бурхан өвчин халуурах шалтгаан болж буйг ямар шинжүүдээр батлах вэ?

1. Түгээмэл толбон гүвдрүүн тууралт дээрээсээ доошоо шаталж гарна
2. Ханиах, нус гойжих, нүд улайх шинжийн аль нэг илэрч болно
3. Амны салст улайж, жижиг цагаан толбон тууралт гарна
4. Цэврүүн тууралт арьс, салст, биеийн үсэрхэг хэсгээр гарна
5. Жижиг зангилаат тууралт бүх биеэр гарна, хэвлийн доод хэсгээр шигүүрэх хандлагатай,

ам, хамрын гурвалжин цэвэр байна

/97./ Сэтгэцийн тулгамдсан асуудлаас үүдсэн биеийн ямар эмгэгүүд /психосоматик өвчнүүд/ байдаг вэ?

1. Даралт ихсэх
2. Зүрхний шигдээс
3. Ходоод гэдсэнд үрэвсэл, шархлаа үүсэх
4. Бамбай булчирхайн хордлого үүсэх
5. Эмэгтэйчүүдийн биений юм хямрах

/98./ Асуумжаар ямар эрсдэлт хүчин зүйл илэрсэн жирэмсэн эмэгтэйг бага эмч дараах шатны эмнэлэг рүү шилжүүлэх вэ?

1. Анхны төрөлт
2. 18-аас доош настай
3. Өмнө нь 5-аас олон удаа төрж байсан
4. Өмнөх хүүхэд амьгүй төрсөн
5. Өмнө нь кесар хагалгаагаар төрсөн эсвэл өмнөх төрөлтөнд цус их алдсан

/99./ Ямар нярайд котримоксазолыг өгч болохгүй вэ?

1. Шарлалттай , 1 сар хүрээгүй
2. Тархины даралттай
3. Дутуу төрсөн, нэг сар хүрээгүй

4. Хүй нь идээтэй
 5. Арьсан дээр идээт цэврүүтэй
- /100./ Чихрийн шижингийн шалтгаан аль нь вэ?
1. Таргалалт
 2. Удамшил
 3. Хоол хүнсний хэрэглээ
 4. Архаг идээт голомтот үрэвсэл
 5. Тархины гэмтэл
- /101./ Жирэмсэн эхэд хорт зуршилын хор уршигын талаар юуг зөвлөх вэ?
1. Жирэмсэн эх тамхи татах нь жин багатай, төрөлхийн бүтэлттэй хүүхэд төрүүлэх магадлал их байдаг
 2. Тамхичин эхээс төрсөн хүүхэд гэнэт нас барах аюултай
 3. Согтууруулах ундаа хэрэглэж болохгүй, учир нь оюуны хомсдолтой хүүхэд төрөх магадлал өндөр байдаг.
4. Тамхи татах нь төрөх үеийн сулрал үүсгэдэг
 5. Архи уух нь төрөх үед цус алдалт үүсгэдэг
- /102./ Багтраатай өвчтөний амьсгаадалтыг намдаахад хамгийн гол эмчилгээ юу вэ?
1. Эуфиллин
 2. Антибиотик
 3. Сальбутамол
 4. Хатгалт хийж үнхэлцгэнд буй шингэнийг соруулж авах
 5. Панангин
- /103./ 3 настай хүүхэд ханиалгаж байгаа ба түүний амьсгал 1 минутанд 48 байна. Өөр эмгэг шинжгүй. Түүний амьсгал олширсон уу? Хэрхэн ангилах вэ?
1. Амьсгал олшроогүй
 2. Амьсгал олширсон
 3. "Ханиад шуухнаа" гэж ангилна
 4. "Уушгины хатгалгаа" гэж ангилна
 5. "Уушгины хүнд хатгалгаа" гэж ангилна
- /104./ Сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний хүрээнд бага эмч юу хийх ёстой вэ?
1. Хүн амын дунд сэтгэцийн эрүүл мэндийн анхдагч урьдчилан сэргийлэлтийн ажлыг зохиох
 2. Хүн амд сэтгэцийн эрүүл мэндийн анхдагч түвшний боловсрол олгох
 3. Хүн амын дунд зонхилон тохиолдож буй сэтгэцийн 4 өвчнийг оношлох, эмчлэх, дахилтаас сэргийлэх арга хэмжээ авах
 4. Нийгмийн бэрхшээлүүдийг шийдвэрлэснээс сэтгэцийн тулгамдсан асуудалгүй болгох
 5. Архи, тамхины таксийг ихэсгэх журмаар тэмцэх
- /105./ Төмөр дутагдлын цус багадалтын шалтгааныг заана уу?
1. Ойр ойрхон жирэмслэх
 2. Цус алдах, сарын тэмдэг их хэмжээгээр ирэх
 3. Архаг голомтот идээт үрэвсэл
 4. Биед төмөр хангалтгүй хэмжээгээр орох
 5. Ходоод, гэдэсний хагалгаа хийлгэсний дараа
- /106./ "Нянгийн хүнд халдвар байж болзошгүй" гэж ангилагдсан нярайд пенициллин, гентамициныг ямар тунгаар тарих вэ?
1. Гентомициныг 5 мг\кг
 2. Гентомициныг 2,5 мг\кг
 3. Пенициллиныг 100000 нэгж\кг
 4. Пенициллиныг 50000 нэгж\кг
 5. Нярайд эдгээр антибиотикийг тарихгүй
- /107./ Толгой өвдөж буй өвчтөнд мэнэн байж бозошгүйг ямар шинжүүдээр батлах вэ?
1. Дагзны булчин хөшингө шинж
 2. Артерийн даралт ихсэх шинж

3. Брудзинскийн дээд, дунд, доод шинж

4. Ууц нуруугаар өвдөх шинж

5. Халуурах шинж

/108./ Гүйлсэн булчирхайн цочмог үрэвсэл халуурах шалтгаан болж буйг ямар шинжүүдээр батлах вэ?

A. Биеэр түгээмэл улаан тууралт шатлаж гарна

B. Цустай суулгана

C. Дагзны булчин хөшингө шинж илэрнэ

D. Гүйлсэн булчирхай улайж, хөөнгөтөж, идээлсэн байна

E. Ханиах, нус гойжих шинж илэрнэ

/109./ Сар гаруй суулгасан, өчигдрөөс баасанд нь цус харагдсан, нүд нь хонхойсон, шингэн ховдоглон ууж буй, арьсны хуниас хэвийн арилж буй, ууртай, цочромтгой болсон 1 настай хүүхдэд ямар ангилал тавих вэ?

A. Ужиг суулгалт

B. Шингэн их алдалттай суулгалт

C. Шингэн алдалтгүй суулгалт

D. Шингэн алдалттай, хүнд ужиг, цусан суулгалт

E. Дисбактериоз.

/110./ Бамбай булчирхайн бүтцийн өөрчлөлтийг илрүүлэх гол шинжилгээг нэрлэнэ үү?

A. Бамбай булчирхайд цацраг идэвхит иодын шингээлт үзэх

B. Термографи

C. Бамбай булчирхайн зураг авах

D. ЭХО

E. Цусан бамбайн даавруудыг тодорхойлох

/111./ 4 настай хүүхдийн чихнээс ногоон булаг гараад сар болж байна. Чих өвдөж байна гэж хэлдэггүй, халуурдаггүй, зовиур шаналгаа илэрдэггүй боловч ээж нь үзүүлэхээр авчирсан. Үзлэгээр өвдөлт ба хөхлөг ургацын үрэвслийн шинжгүй. Хүүхдийг хэрхэн ангилах вэ?

A. Чихний цочмог халдвар

B. Чихний архаг халдвар

C. Чихний өвчин байхгүй

D. Хөхлөг ургацын үрэвсэл

E. Нойтон хульх

/112./ Түнх хоорондын зай хэд байх ёстой вэ?

A. 10-15

B. 15-19

C. 20-21

D. 30-31

E. 25-26

/113./ Хооллолтын бэрхшээлтэй хүүхдийг хэд хоноод үзэх вэ?

A. 2 хоноод

B. 5 хоноод

C. 10 хоноод

D. 14 хоноод

E. 30 хоноод

/114./ Умайн салстын архаг үрэвслийн үед илрэх эмнэлзүйн гол шинж тэмдэг юу вэ?

A. Халуурах

B. Сарын тэмдэг хаагдах

C. Хэвлийн доод хэсгээр хүчтэй өвдөх

D. Сарын тэмдгийн мөчлөг алдагдах

E. Цусархаг шингэн байнага гарах

/115./ Цус багадалттай 1,6 настай хүүхдэд төмрийн фолатыг ямар тунгаар, яаж өгөх вэ?

A. 1\4 шахмалаар өдөрт нэг удаа 14 хоногийн турш

B. 1\2 шахмалаар өдөрт нэг удаа 14 хоногийн турш

C. 1 шахмалаар өдөрт нэг удаа 14 хоногийн турш

D. 1,5 шахмалаар өдөрт нэг удаа 14 хоногийн турш

- Е. 2 шахмалаар өдөрт нэг удаа 14 хоногийн турш
- /116./ Улаанбурхэнтай 4 настай хүүхдэд А аминдэмийн 100000 нэгжтэй, хөх капсулыг яаж өгөх вэ?
- А. 1 капсулыг яаралтай өг, маргааш уулгах 1 капсулыг эхэд нь зааж өг.
 - В. 1\2 капсулыг яаралтай өг, маргааш уулгах 1\2 капсулыг эхэд нь өг
 - С. 1 капсулыг яаралтай өг
 - Д. 2 капсулыг яаралтай өг, маргааш уулгах 2 капсулыг эхэд нь өг.
 - Е. 3 капсулыг яаралтай өг
- /117./ Леопольдийн 2-р аргаар юуг тодорхойлох вэ?
- А. Умайн ёроолын өндрийн түвшин
 - В. Ургийн байрлал, хэлбийлт
 - С. Түрүүлсэн хэсэг
 - Д. Ургийн түрүүлсэн хэсэг бага аарцгийн орох хэсэгтэй харьцах байдал
 - Е. Ургийн жин
- /118./ Чихнээс булаг гарч буй 2 сар хүрээгүй нярайд ямар арга хэмжээ авах вэ?
- А. Үүсгэгчийн эсрэг эмийн эхний тунг булчинд тариад, эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
 - В. Үүсгэгчийн эсрэг эм уулган, чихийг чихээсээр цэвэрлэн гэрээр эмчилнэ.
 - С. Чихэнд ус төрөгчийн хэт исэл дусаан, антибиотиктой уусмалаар угаана
 - Д. Гидрокортизонтой чихээс чихэнд хийж орхино
 - Е. Чихийг хөхний сүүгээр угаахыг зөвлөнө
- /119./ Туберкулины сорилын хариу урвалыг хэзээ хэмжиж тодорхойлох вэ?
- А. 72 цагийн дараа
 - В. 48 цагийн дараа
 - С. 24 цагийн дараа
 - Д. 2-3 долоо хоногийн дараа
 - Е. Сорилыг даруй уншина
- /120./ “Шингэн алдалттай суулгалт” гэж ангилагдсан хүүхдэд 4 цагийн турш ямар хэмжээний шингэн уулгах вэ?
- А. 50мл
 - В. 100мл
 - С. 200 мл
 - Д. 400 мл
 - Е. Хүүхдийн биеийн жинг 75 мл-т үржүүлээд гарах хэмжээгээр шингэнийг уулгана.
- /121./ Зүрхний бахын үед ямар хүндрэл гарах вэ?
- А. Зүрхний шигдээс
 - В. Зүрхний гаралтай шок
 - С. Зүрхний багтраа
 - Д. Тархинд цус харвах
 - Е. Таталт өгөх
- /122./ Чихнээс булаг гарч буй хүүхдийн чихийг чихээсээр хэрхэн цэвэрлэх вэ?
- А. Хоногт 3-аас доошгүй удаа чихийг чихээсээр хуурайштал цэвэрлэнэ. Чих хуурайштал эмчилгээг үргэлжлүүлнэ
 - В. Өглөө чихээс хийж орхиод орой чихээсийг шинээр солино.
 - С. Хоногт нэг удаа өрхийн эмчээр чихээс хийлгэж байна
 - Д. Хоногт нэг удаа ээж нь чихээс хийнэ
 - Е. Хоногт нэг удаа чихээсийг 5 хоногийн турш хийнэ.
- /123./ 38,5 хэмээс дээш халуурч буй 8 сартай хүүхдэд парацетамолын 100 мг-ын шахмалаас яаж өгөх вэ?
- А. 1\4
 - В. 1\2
 - С. 1 бүтнээр
 - Д. 1,5
 - Е. 2 ш-ээр
- /124./ Жирэмсний аль үеийн ходлого жирэмсний амь насанд илүү аюултай вэ?
- А. Жирэмслэлт бол физиологийн процесс тул амь насанд аюулгүй

- В. Жирэмсний эрт үеийн хордлого
С. Жирэмсний хожуу үеийн хордлого
D. Жирэмсний эрт үеийн хордлого физиологийн процесс тул амь насанд аюулгүй.
E. Жирэмсний хожуу үеийн хордлого физиологийн процесс тул амь насанд аюулгүй.
- /125./ Тархмал хордлогот бахуутай хүний сувилгаанд аль нь хамаарах вэ?
A. Халуун усанд оруулна.
B. Хүйтэн усанд оруулна
C. Гэрэлтүүлэг багатай өрөөнд байлгах
D. Гичтэй усанд оруулна
E. Хуурай халуун байранд байлгана
- /126./ Трихомонадын гаралтай үтрээний үрэвслийн үед доорх эмийг хэрэглэхгүй:
A. Трихопол
B. Метронидазол
C. Метрогел
D. Клотримазол
E. Клион
- /127./ 6-12 сартай хөхөө хөхдөг хүүхдэд нэмэгдэл хоолнуудад дасгасны дараа өдөрт хэдэн удаа нэмэлт хоол өгөх вэ?
A. 1 удаа
B. 2 удаа
C. 3 удаа
D. 4 удаа
E. 5 удаа
- /128./ Ходоод гэдэсний шархлаа гэж сэжиглэгдсэн үед хийх шинжилгээг нэрлэнэ үү?
A. Ходоодны шүүсийг шинжлэх
B. Цусны ийлдэст гастрины түвшинг тодорхойлох
C. Цэсний хүүдийн зураг авах
D. Хэвлийг рентгенээр харах
E. Ходоод гэдэсийг дурандах
- /129./ Сарын тэмдэгийн мөчлөгийн хугацааг яаж тогтоох вэ?
A. Сарын тэмдэг ирээд дууссан өдрөөс дараагийн сарын тэмдэгийн анхны өдөр хүртэл
B. Сарын тэмдэг ирсэн анхны өдрөөс дараагийн сарын тэмдгийн анхны өдөр хүртэл
C. Сарын тэмдэг ирээд дууссан өдрөөс дараагийн сарын тэмдэг дууссан өдрийг хүртэл
D. Сарын эхний 5 хоног
E. Сарын сүүлийн 5 хоног
- /130./ Шуугиант амьсгал хяхтнаа амьсгалаас юугаар ялгаатай вэ?
A. Амьсгал авахад шуугиантай, зовиуртай
B. Амьсгал гаргахад шуугиантай, зовиуртай
C. Амьсгал авах, гаргах нь шуугиантай, зовиуртай
D. Амьсгал гаргахад хожигноо сонсогдоно
E. Уушги чагнахад гуурсан хоолойн амьсгал сонсогдоно
- /131./ Улаанбурхэнтай 9 сартай хүүхдэд А аминдэмийн 100000 нэгжтэй, хөх капсулыг яаж өгөх вэ?
A. 1 капсулыг яаралтай өг, маргааш уулгах 1 капсулыг эхэд нь зааж өг
B. 1\2 капсулыг яаралтай өг, маргааш уулгах 1\2 капсулыг эхэд нь өг.
C. 1 капсулыг яаралтай өг
D. 2 капсулыг яаралтай өг.
E. 3 капсулыг яаралтай өг
- /132./ Суулгаж байгаа хүүхдэд товлолын дагуу саагийн вакцин уулгах уу?
A. Уулгах боловч тунг хийсэнд тооцохгүй, дараа сар нөхөж уулгана
B. Дархлаа тогтохгүй учир уулгахгүй
C. Уулгаад товлолын дагуу уусанд тооцно
D. Уулгахгүй, товлолыг хойшлуулна
E. Хэзээ ч уулгахгүй

/133./ 38.5 хэмээс дээш халуурч буй 1 нас 5 сартай хүүхдэд парацетамолын 500 мг шахмалыг яаж уулгах вэ?

- A. 1\4-ээр
- B. 1\2-ээр
- C. 1,5-аар
- D. 1 ш-ээр
- E. 2ш-ээр

/134./ Уушгины үрэвслийн үед халдварын эсрэг ямар эмийг сонгох вэ?

- A. Антибиотек
- B. Антиоксидант
- C. Антигистамин
- D. Хордлогын эсрэг эмчилгээ
- E. Дархлаа дэмжих эмчилгээ

/135./ Зүрхний шигдээсийн үед хамгийн элбэг тохиолддог хүндрэл аль нь вэ?

- A. Зүрхний гаралтай шок
- B. Уушигны хаван
- C. Артерийн даралт ихсэх
- D. Зүрх цусаар чихэлдэх
- E. Тосгуур ховдлын бүрэн хориг үүсэх

/136./ Аарцгийн сэртэн хоорондох зай /Dis. Spinarum / хэд байх ёстой вэ?

- A. 10-15
- B. 15-19
- C. 20-21
- D. 25-26
- E. 27-30

/137./ “Рахитгүй” гэж ангилагдсан хүүхдэд Д аминдэмийн 50000 нэгжийн шахмалаас ямар тунгаар, хэдийд өгөх вэ?

- A. Нэг удаа 1 шахмал уулгана
- B. Даваа гариг бүрт 1 удаа 1 шахмалыг 1 сар өгнө
- C. 6,7,8,9-р саруудад урьдчилан сэргийлэх тунг уулгахгүй. Бусад саруудад 14 хоногтойгоос эхлээд 1 шахмалыг 2 нас хүртэл сар бүр уулгана.
- D. Рахитгүй тул Д аминдэм уулгахгүй
- E. Даваа, Пүрэв гариг бүрт нэг удаа 1 шахмалаар, нийт 7 удаа өгнө

/138./ Леопольдийн 1-р аргаар юуг тодорхойлох вэ?

- A. Умайн ёроолын өндрийн түвшин
- B. Ургийн байрлал
- C. Түрүүлсэн хэсэг
- D. Ургийн түрүүлсэн хэсэг бага аарцгийн орох хэсэгтэй харьцах байдал
- E. Ургийн жин

/139./ 3 настай “Шингэн алдалтгүй суулгалттай” хүүхдэд суулгалт бүрийн дараа ямар хэмжээний шингэн уулгах вэ?

- A. 50-100 мл
- B. 100-200 мл
- C. 500-600 мл
- D. 1000 мл
- E. 1500 мл

/140./ Чихний цочмог халдвартай хүүхдийн чихний өвдөлтийг намдаахаар юу зөвлөх вэ?

- A. Чихэнд фурациллинтэй спирт дусаах
- B. Парацетамолыг 6 цагаар өвдөлт намдтал уулгах
- C. Чихэнд тарвагны тос дусаах
- D. Чихэнд хөхний сүү дусаах
- E. Чихэнд пенициллин дусаах

/141./ 4 настай хүүхэд 4 хоног, өдөрт 5 удаа шингэн суулгасан, баасанд цус байхгүй, орчиндоо хэвийн харьцаатай, хоол ундандаа сайн, нүд хонхоогоогүй, арьсны хуниас хэвийн арилж байна. ХӨЦМ-ийн дагуу хэрхэн ангилах вэ?

- A. Шингэн алдалтгүй суулгалт
 - B. Шингэн алдалттай суулгалт
 - C. Шингэн их алдалттай суулгалт
 - D. Шингэн алдалтгүй ужиг суулгалт
 - E. Шингэн алдалттай ужиг суулгалт
- /142./ В гепатитын нууц үе дунджаар хэд хоног үргэлжилдэг вэ?
- A. 10-15 хоног
 - B. 10-45 хоног
 - C. 45-90 хоног
 - D. 50-180 хоног
 - E. 2-4 долоо хоног
- /143./ Хүүхдэд цээж хонхолзох шинж илэрч байвал бага эмч хэрхэн ангилах вэ?
- A. Ханиад шуухнаа
 - B. Уушгины хүнд хатгалгаа
 - C. Уушгины хатгалгаа
 - D. Багтраа
 - E. Ларингит
- /144./ Уураг дутагдлын хаван ямар өвчтөнд илүүтэй тохиолдох вэ?
- A. Зүрхний дутагдалтай
 - B. Харшилтай
 - C. Хүнд тураалтай
 - D. Амьсгалын дутагдалтай
 - E. Амьсгалын замын халдвартай
- /145./ Төмрийн фолатыг хүнд цус багадалттай эмэгтэйд төрсний болон үр хөндүүлсний дараа яаж уулгах вэ?
- A. Өдөрт хагас шахмалыг уулгана
 - B. Өдөрт хагас шахмалаар 3 сарын турш уулгана
 - C. Өдөрт 1 шахмалыг уулгана
 - D. Өдөрт 2 шахмалаар 3 сарын турш уулгана
 - E. Өдөрт 2 удаа 1 шахмалаар жирэмсний турш уулгана
- /146./ Заг хүйтнийг үүсгэгч гонококк эмэгтэйн шээс, бэлгийн замын хаана илүүтэй байрлах вэ?
- A. Давсаг
 - B. Шээсний сүв
 - C. Шээс дамжуулах цорго
 - D. Умай
 - E. Өндгөвч
- /147./ 8 сартай хүүхэд халуурсан, татсан зовиуртай үзүүлэхэд хүүхдийн халуун 38 хэм, таталт намдсан боловч маш их шаналгаатай, чихнээс булаг гойжоод сар болж байгаа. Үзлэгээр чихний ард хүндүүр хавагнасан улайлт байв. Хүүхдийг хэрхэн ангилах вэ?
- A. Аюултай ерөнхий шинжтэй. Чихний архаг халдвар
 - B. Маш хүнд халууралт өвчин. Хөхлөг ургацын үрэвсэл
 - C. Халууралт. Чихний архаг халдвар
 - D. Халууралт. Чихний цочмог халдвар
 - E. Чихний цочмог халдвар
- /148./ 1-ээс дээш насны хүүхдэд нэмэгдэл хоолыг нэг удаа хэдий хэмжээтэй өгөх вэ?
- A. 1 1/4-1 1/2 аяга буюу 250-300 мл
 - B. 1 аяга буюу 200 мл
 - C. 50 мл-ээр ойр ойрхон
 - D. 100 мл-ээр ойр ойрхон
 - E. Хүссэн хэмжээгээр
- /149./ Улаанбурхэнтай 10 сартай хүүхдэд А аминдэмийн 200000 нэгжтэй, улаан капсулыг яаж өгөх вэ?
- A. 1 капсулыг яаралтай өг, маргааш уулгах 1 капсулыг эхэд нь зааж өг.
 - B. 1\2 капсулыг яаралтай өг, маргааш уулгах 1\2 капсулыг эхэд нь зааж өг
 - C. 1 капсулыг яаралтай өг.

- D. 2 капсулыг яаралтай өг
E. 3 капсулыг яаралтай өг.
- /150./ Цусанд ямар бодис ихэссэнээс арьс салст шарладаг вэ?
A. Билирубин
B. Холестрин
C. Амилаза
D. Уураг
E. Сахар
- /151./ 3 сартай зөвхөн хөхөө хөхдөг “Шингэн алдалтгүй суулгалттай” хүүхдэд ямар шингэн уулгахыг зөвлөх вэ?
A. Хөхөө ойр ойрхон хөхүүлэх, суулгалт бүрийн дараа шингэлсэн шөл уулгах
B. Хөхөө ойр ойрхон хөхүүлэх, суулгалт бүрийн дараа будааны шүүс уулгах.
C. Хөхөө ойр ойрхон хөхүүлэх, суулгалт бүрийн дараа тараг, хярам уулгах
D. Хөхөө ойр ойрхон хөхүүлэх, суулгалт бүрийн дараа буцалсан ус, ШСДУ уулгах
E. Зөвхөн ШСДУ уулгах
- /152./ Зимницкийн сорилоор юу тодорхойлох вэ?
A. 1 минутын диурез, бөөрний түүдгэнцэрийн шүүх ажиллагааг үзнэ.
B. Шингэний ачаалал өгч бөөрний шингэрүүлэлтийн ажиллагааг үзнэ
C. 1 мл шээсээр ялгарч байгаа дүрст элементийг тодорхойлно
D. 24 цагийн шээсэнд дүрст элементийг тодорхойлно
E. Бөөрний үйл ажиллагааг үзнэ
- /153./ Эмэгтэйчүүдийн ямар өвчнийг арын хүнхрээгээр хатгалт хийж оношлох вэ?
A. Умайн хүзүүний шархлаа
B. Умайн хоргүй хавдар
C. Умайн гадуурхи жирэмслэлт
D. Даавруудын цочмог үрэвсэл
E. Үргүйдэл
- /154./ “Рахиттай” гэж ангилагдсан хүүхдэд Д аминдэмийн 50000 нэгжийн шахмалаас ямар тунгаар өгөх вэ?
A. Сард нэг удаа 1 шахмалыг , 2 нас хүртэл
B. Даваа гариг бүрт 1 удаа 1 шахмалыг 1 сар өгнө
C. Даваа, Пүрэв гариг бүрт нэг удаа 1 шахмалаар , нийт 7 удаа өгнө
D. Сард нэг удаа 1 шахмалыг 1 жил уулгана
E. Сард нэг удаа 1 шахмалыг 2 жил уулгана
- /155./ Цус багадалттай хүүхдийг хэд хоноод давтан үзэх вэ?
A. 2 хоноод
B. 5 хоноод
C. 10 хоноод
D. 14 хоноод
E. 30 хоноод
- /156./ 8 сартай 9 кг жинтэй, “Шингэн алдалттай суулгалт” гэж ангилагдсан хүүхдэд 4 цагийн турш ямар хэмжээний шингэн уулгах вэ?
A. 200 мл
B. 600-800 мл
C. 1200-1400 мл
D. 400 мл
E. 2000 мл
- /157./ Ходоодны В хэлбэрийн архаг үрэвслийн үндсэн шалтгаан юу вэ?
A. Удамшил
B. Сэтгэл санааны цочрол
C. Хелико бактер
D. Хоолны дэглэм алдагдах
E. Эмийг буруу хэрэглэх
- /158./ 3 настай уушгины хатгалгаатай хүүхдэд амоксициллины 250 мг шахмалаас яаж өгөх вэ?

- A. 1/2-ээр өдөрт 2 удаа 5 хоног
 - B. 1 шахмалаар өдөрт 2 удаа 5 хоног
 - C. 1 шахмалаар өдөрт 3 удаа 5 хоног
 - D. 1/4 шахмалаар өдөрт 4 удаа 5 хоног
 - E. 2 шахмалаар өдөрт 2 удаа 5 хоног
- /159./ Аарцгийн гадна шулуун хэмжээ /conugata externa/ хэд байх ёстой вэ?
- A. 10-15
 - B. 15-19
 - C. 20-21
 - D. 22-25
 - E. 25-30
- /160./ А гепатитын нууц үе дунджаар хэд хоног үргэлжилдэг вэ?
- A. 10-15 хоног
 - B. 10-45 хоног
 - C. 45-90 хоног
 - D. 50-180 хоног
 - E. 2-4 сар
- /161./ Ихэс түрүүлсэн үед ямар шинжилгээ яаралтай хийж оношийг батлах вэ?
- A. Үтрээний үзлэг
 - B. Рентген шинжилгээ
 - C. Цистографи
 - D. Чанд авиан шинжилгээ
 - E. Маммографи
- /162./ “Чихний архаг халдвартай” гэж ангилсан, өөр ангилалгүй хүүхдэд ямар тусламж үзүүлэх вэ?
- A. Үүсгэгчийн эсрэг эм, өвдөлт намдаах эм өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
 - B. Үүсгэгчийн эсрэг эм 5 хоног өгөөд, өвдөлт намдаах ба чихээсээр чихийг цэвэрлэх эмчилгээ заагаад гэрээр эмчилнэ
 - C. Чихээсээр чихийг хуурайшуулахыг зааж өгөөд 5 хоноод давтан үзүүлэхийг ба хэзээ яаралтай эргэж үзүүлэхийг зөвлөнө.
 - D. Антибиотик тарина
 - E. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
- /163./ Төмрийн фолатыг хүнд цус багадалттай жирэмсэнд яаж уулгах вэ?
- A. Жирэмсний турш өдөрт хагас шахмалыг ууна.
 - B. Өдөрт хагас шахмалаар 3 сарын турш ууна.
 - C. Жирэмсний турш өдөрт 1 шахмалыг ууна
 - D. Өдөрт 2 шахмалаар 3 сарын турш уугаад, залгаад жирэмсний турш 1 шахмалаар ууна
 - E. Өдөрт 2 удаа 1 шахмалаар жирэмсний турш ууна
- /164./ 6 сартай хүүхэд өчигдөрөөс халуурсан, тайван биш болсон зовиуртай, үзүүлэхэд чихнээс булаг гарч байв. Эх нь хүүхдийн чихнээс урд өмнө булаг гарч байсныг анзаараагүй тул хэд хоног гарч байгааг мэдэхгүй. Өөр шинжүүд илрээгүй. Хүүхдийг хэрхэн ангилах вэ?
- A. Халууралт. Чихний цочмог халдвар
 - B. Халууралт. Чихний архаг халдвар
 - C. Хөхлөг ургацын үрэвсэл
 - D. Маш хүнд халууралт өвчин
 - E. Чихний архаг халдвар
- /165./ Хяхтнаа амьсгал юугаар ялгагдах вэ?
- A. Амьсгал авахад шуугиантай, зовиуртай
 - B. Амьсгал гаргахад шуугиантай, зовиуртай
 - C. Амьсгал авах, гаргах нь шуугиантай, зовиуртай
 - D. Амьсгал гаргахад хожигноо сонсогдоно
 - E. Уушги чагнахад гуурсан хоолойн амьсгал сонсогдоно
- /166./ Улаанбурхэнтай 2 настай хүүхдэд А аминдэмийн 200000 нэгжтэй, улаан капсулыг яаж өгөх вэ?
- A. 1 капсулыг яаралтай өг, маргааш уулгах 1 капсулыг эхэд нь зааж өг

- В. 1/2 капсулыг яаралтай өг, маргааш уулгах 1/2 капсулыг эхэд нь өг
С. 1 капсулыг яаралтай өг
D. 2 капсулыг яаралтай өг.
E. 3 капсулыг яаралтай өг.
- /167./ Өвчтөний амьсгадалт багтраагаас шалтгаалж буйг ямар шинжүүдээр батлах вэ?
A. Амьсгал авах үедээ саадтай буюу шуугиантай
B. Амьсгал гаргах үедээ саадтай буюу шуугиантай
C. Хяхтанаж амьсгалах
D. Хоолой сөөх
E. Хуцуулж ханиах
- /168./ Элэгний архаг хэлбэрийн үрэвслийн үед аль шинж нь түгээмэл илрэх вэ?
A. Элэгний үйл ажиллагааны дутагдал
B. Өвдөлтийн хам шинж
C. Боловсруулалтын хямралын хам шинж
D. Мэдрэл сульдлын хам шинж
E. Цусархаг хам шинж
- /169./ Жирэмснээс хамгаалахын тулд бэлгэвчийг хэдийд хэрэглэх нь тохиромжтой вэ?
A. Биений юм ирсэн эхний өдрөөс эхлэн өдөр бүр нэг шахмалыг ууна
B. Биений юм ирсэн 5 дахь өдрөөс эхлэн өдөр бүр нэг шахмалыг ууна.
C. 12 долоо хоног буюу 3 сар тутам нэг удаа бульчинд тарина.
D. Биений юм ирсэн 3 дахь өдөр
E. Бэлгийн хавьталд орохын өмнө тогтмол
- /170./ Хэсэг газрын нянгийн халдвартай 3,6 кг жинтэй нярайд амоксациллины 250 мг шахмалаас ямар тунгаар , яаж өгөх вэ?
A. 1/4 шахмалаар хоногт 3 удаа 5 хоног
B. Тал шахмалаар хоногт 3 удаа 5 хоног
C. 1/4 шахмалаар хоногт 4 удаа 5 хоног
D. Тал шахмалаар хоногт 4 удаа 5 хоног
E. Нэг шахмалаар хоногт 4 удаа 5 хоног
- /171./ Цэсний хүүдийн архаг үрэвслийн шалтгаан юу вэ?
A. Удамшил
B. Сэтгэл санааны цочрол
C. Цаг уурын өөрчлөлт
D. Халдвар
E. Витамин дутагдал
- /172./ Ургийн буруу байрлал ямар эмгэгийн үед илүүтэй тохиолдох вэ?
A. Тулгар жирэмсэн
B. Жирэмсний хордлого
C. Төрөх хүчний сулрал
D. Ихэс түрүүлэлт
E. Төрөх үеийн цус алдалт
- /173./ Сампингийн эрхийн шинжийг хаана тэмтэрч үзэх вэ?
A. Өвчүүний эрмэгээр
B. Хавирганы ясан ба мөгөөрсөн хэсгийн уулзвар дээр
C. Суганы дунд шугамаар
D. Суганы арын шугамаар
E. Өвчүүн дээр
- /174./ Ихэс түрүүлэх үеийн үндсэн шинж тэмдэг юугаар илрэх вэ?
A. Өвдөх
B. Цус алдах
C. Ургийн ус эрт гарах
D. Ургийн зүрхний цохилт хурдсах
E. Хавагнах
- /175./ 3 настай цусан суулгалттай хүүхдэд котримоксазолын 480 мг шахмалаас яаж уулгах вэ?

- A. 1 шахмалаар хоногт 4 удаа уулгана
 - B. Тал шахмалаар хоногт 4 удаа уулгана
 - C. Тал шахмалаар хоногт 3 удаа суулгалт намдтал уулга
 - D. 1 шахмалаар хоногт 2 удаа 5 хоногийн турш уулгана
 - E. 2 шахмалаар хоногт 1 удаа суулгалт намдтал уулгана
- /176./ Хөхлөг ургацын үрэвсэлтэй хүүхдэд ямар тусламж үзүүлэх вэ?
- A. Үүсгэгчийн эсрэг эм, өвдөлт намдаах эмийн эхний тунг өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
 - B. Үүсгэгчийн эсрэг эм 5 хоног өгөөд гэрээр эмчилнэ
 - C. Өвдөлт намдаах эм өгөөд гэрээр эмчилнэ
 - D. Чихээсээр чихийг цэвэрлэх эмчилгээ заагаад гэрээр эмчилнэ.
 - E. Үүсгэгчийн эсрэг эм 5 хоног өгөөд, өвдөлт намдаах ба чихээсээр чихийг цэвэрлэх эмчилгээ заагаад гэрээр эмчилнэ
- /177./ ХӨЦМ-ийн дагуу “Уушгины хатгалгаа” гэдэг ангиллыг бага эмч ямар шинжийг үндэслэн тавих вэ?
- A. Амьсгал олшрох, ханиалгах
 - B. Цээж хонхолзох, ханиалгах
 - C. Хяхтнаа амьгал, ханиалгах
 - D. Өндөр халуурах
 - E. Шуугиантай амьгал
- /178./ 3 сартай хүүхэд нэг хоног толгойгоо шөргөөж уйлна. Түүний чихэнд хүрэхэд маш их эмзэглэн чанга уйлж байв. Чихний ард хөндүүр хаван байхгүй байна. Хэрхэн ангилах вэ?
- A. Чихний цочмог халдвар
 - B. Хөхлөг ургацын үрэвсэл
 - C. Чихний архаг халдвар
 - D. Аюултай ерөнхий шинжтэй
 - E. Маш хүнд өвчин
- /179./ Туберкулины сорилыг хаана хийх вэ?
- A. Булчинд
 - B. Судсанд
 - C. Арьсан дор
 - D. Арьсан дотор
 - E. Арьсан дээр
- /180./ Багтраа өвчний цэр ямар онцлогтой вэ?
- A. Өтгөн ногоон цэр
 - B. Салсархаг шингэн цэр
 - C. Унжралдсан шиллэг цэр
 - D. Цусархаг цэр
 - E. Хөөсөрхөг цэр
- /181./ Зүрхний үнхэлцгэнд шингэн хуримтлагдсанаас амьсгаадаж, айдас түгшүүртэй байгаа өвчтөнд ямар эмчилгээ хамгийн чухал вэ?
- A. Эуфиллин
 - B. Антибиотик
 - C. Сальбутамол
 - D. Хатгалт хийж үнхэлцгэнд буй шингэнийг соруулж авах
 - E. Панангин
- /182./ Төмрийн фолатыг хэвийн явцтай жирэмсэнд яаж уулгах вэ?
- A. Жирэмсний турш өдөрт хагас шахмалыг ууна
 - B. Өдөрт хагас шахмалаар 3 сарын турш ууна
 - C. Жирэмсний турш өдөрт 1 шахмалыг ууна
 - D. Өдөрт 2 удаа 1 шахмалаар жирэмсний турш ууна
 - E. Өдөрт 2 шахмалаар 3 сарын турш уугаад, залгаад жирэмсний турш 1 шахмалаар ууна.
- /183./ Умайн ерөндөгийг хэдийд тавих нь тохиромжтой вэ?
- A. Биений юм ирсэн эхний өдрөөс эхлэн өдөр бүр нэг шахмалыг ууна.
 - B. Биений юм ирсэн 5 дахь өдрөөс эхлэн өдөр бүр нэг шахмалыг ууна.

- C. 12 долоо хоног буюу 3 сар тутам нэг удаа бульчинд тарина.
D. Биений юм ирсэн 3 дахь өдөр
E. Бэлгийн хавьталд орохын өмнө тогтмол
- /184./ Цустай суулгасан нярайг хаана, хэн эмчлэх вэ?
A. Гэрт нь өрхийн эмч эмчилнэ
B. Эмнэлэгт хэвтүүлж эмчилнэ
C. Амбулатороор эмчилнэ
D. Амбулатороор шинжилгээ өгч, шаардлагтай бол эмнэлэгт хэвтүүлнэ.
E. Гэрт нь ээж нь эмчилнэ
- /185./ 38,5 хэмээс дээш хэлуурч буй 4 настай хүүхдэд парацетамолын 500 мг-ын шахмалаас яаж өгөх вэ?
A. 1\4
B. 1\2
C. 1 бүтнээр
D. 1,5
E. 2 ш
- /186./ Хэрлэг төст үений үрэвслийн онцлог шинж юу вэ?
A. Эмгэг голчлон том үеийг хамарч хэрж өвдөнө
B. Хөлийн хурууны үений хурц үрэвсэл
C. Нурууны үе гэмтэж явж чадахгүй болно
D. 2 талд тэгш хэмтэй, жижиг үенээс эхэлж гэмтэнэ
E. Өвдөгний үе хавдаж, шөнөдөө маш хүчтэй өвдөнө
- /187./ Хүүхэд нярайлах хугацааг яаж тогтоох вэ?
A. Сүүлийн сарын тэмдэг ирсэн анхны өдрөөс 3 сарыг хасч, 15 хоног нэмнэ.
B. Сүүлийн сарын тэмдэг ирсэн эцсийн өдрөөс 3 сарыг хасч, 15 хоног нэмнэ.
C. Сүүлийн сарын тэмдэг ирсэн анхны өдрөөс 3 сарыг хасч, 7 хоног нэмнэ
D. Сүүлийн сарын тэмдэг ирсэн анхны өдөр дээр 9 сарыг нэмнэ
E. Сүүлийн сарын тэмдэг ирсэн эцсийн өдөр дээр 10 сарыг нэмнэ.
- /188./ Хүнд тураалтай хүүхдэд ямар арга хэмжээ авах вэ?
A. А аминдэм өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.
B. Хооллолтын байдлыг үнэлэн хоолны зөвлөгөө өгнө.
C. Фермент эмчилгээ хийж гэрт нь эмчилнэ
D. Дексаметазон уулгана.
E. Аминдэмээр гэрт нь эмчилнэ
- /189./ Сар гаруй суулгасан атлаа хоол, ундандаа сайн, орчиндоо хэвийн харьцаатай, нүд хонхоогоогүй, арьсны хуниас хэвийн арилж буй 2 настай хүүхдийг хэрхэн ангилах вэ?
A. Ужиг суулгалт
B. Шингэн их алдалттай суулгалт.
C. Шингэн алдалттай суулгалт.
D. Шингэн алдалтгүй, ужиг суулгалт
E. Шингэн алдалттай, хүнд ужиг, цусан суулгалт
- /190./ Бөмбөрийн цохиур, цагны шилний шинж ямар эмгэгийн үед илрэх вэ?
A. Гуурсан хоолой тэлэгдэх эмгэг
B. Гуурсан хоолойн хурц үрэвсэл
C. Уушигны хурц үрэвсэл
D. Уушигны сүрьеэ
E. Гуурсан хоолойн багтраа
- /191./ 10 сартай. амьсгал гаргалт шуугиантай байгаа хүүхдэд сальбутамолын 4 мг шахмалыг яаж өгөх вэ?
A. 1\2-ээр өдөрт 3 удаа
B. 1\2-ээр өдөрт 4 удаа
C. 1\4-ээр өдөрт 3 удаа
D. 1\4-ээр өдөрт 4 удаа
E. 1 шахмалаар 1 удаа
- /192./ Бага эмч сүрьеэг оношлох шинжилгээний гол арга юу вэ?

- A. Уушгины гэрлийн шинжилгээ
 - B. Мантугийн сорил
 - C. Цусны ерөнхий шинжилгээ
 - D. Цэрний шинжилгээ
 - E. Бронхоскопи
- /193./ Жирэмсний гарцаагүй шинж тэмдэг.
- A. Биений юм хоригдох
 - B. Үтрээ болон умайн хүзүүний салст хөхрөх
 - C. Хэвлийн цагаан шугам, хөхний толгой нөсөөтөх
 - D. Ургийн хэсэг тэмтрэгдэх
 - E. Огиулж бөөлжих.
- /194./ 3 настай хүүхдийн чихнээс булаг гойжоод зовиургүй хагас жил болж байсан. Гэтэл өчигдөрөөс эхлээд хүүхэд халуурч, чих өвдөж байна гэж уйлагнасан. Үзлэгээр чихнээс булаг гарч байсан ба чихний ард хөндүүр хаван байгаагүй. Бусад шинжүүд илрээгүй. Хүүхдийг хэрхэн ангилах вэ?
- A. Халууралт. Чихний цочмог халдвар
 - B. Халууралт. Чихний архаг халдвар
 - C. Чихний өвчин байхгүй
 - D. Хөхлөг ургацын үрэвсэл.
 - E. Халууралт. Нойтон хульх
- /195./ Хэрлэг төст үений үрэвслийн онцлог шинж юу вэ?
- A. Эмгэг голчлон том үеийг хамарч хэрж өвдөнө
 - B. Хөлийн хурууны хурц үрэвсэл
 - C. Нурууны үе гэмтэж явж чадахгүй болно
 - D. 2 үе тэгш хэмтэй гэмтэж өглөөд бадайрч хөшнө
 - E. Өвдөгний үе хавдаж шөнөдөө маш хүчтэй өвдөнө
- /196./ Улаанбурханы вакциныг хэдэн насанд нь хийх вэ?
- 1. 2 сартайд
 - 2. 8-11 сартайд
 - 3. 4 сартайд
 - 4. 1 нас 2-6 сартайд
 - 5. 2 настайд
- /197./ “Завдсан зулбалт” гэдэг ангилалтай эмэгтэйд ямар тусламж үзүүлэх вэ?
- 1. Тохирох антибиотیکیг булчинд, судсанд тарина
 - 2. 4-6 цаг ажиглаад цус алдалт багасахгүй бол эмнэлэгт шилжүүлнэ.
 - 3. Судсаар дусал хийнэ.
 - 4. Цус алдалт намдвал гэрт нь хариулна, 2 хоноод давтан үзүүлэхийг зөвлөнө.
 - 5. Умайд иллэг хийнэ
- /198./ Жирэмсний эрт үеийн хордлого ямар шинжүүдээр илэрдэг вэ?
- 1. Огиулж бөөлжих
 - 2. Хоолонд дургүй болох
 - 3. Үнэрлэх, амтлах мэдрэхүй өөрчлөгдөх
 - 4. Даралт ихсэх
 - 5. Хавагнах
- /199./ Хавантай өвчтөнд бага эмч ямар тусламж үзүүлэх вэ?
- 1. Хоолонд давс хязгаарлах ба харшил үүсгэдэг хүнсний бүтээгдэхүүнийг хориглоно
 - 2. Хаван хөөх зорилгоор шээс хөөх эм хэрэглэнэ
 - 3. Шалтгааныг тогтоож, шалтгааны ба эмгэг жамын эсрэг эмчилгээ хийнэ, үр дүн өгөхгүй бол эмнэлэгт хэвтүүлнэ
 - 4. Физиологийн уусмал дуслаар хийнэ
 - 5. Реополиглюкин эсвэл полиглюкин дуслаар хийнэ
- /200./ Шингэн их алдалттай суулгалтын шинжүүдийг заа:
- 1. Унтаарсан, ухаангүй, ууж чадахгүй
 - 2. Нүд хонхойх
 - 3. Арьсны хуниас маш удаан буюу 2 секундээс удаан арилах

4. Тайван биш, цочромтгой
 5. Цангасан, ховдоглон уух
- /201./ Зүрхний бах өвчин гэж юу вэ?
1. Судас хатуурах өвчин
 2. Титэм судсаар очих цусны хэмжээ дутагдах
 3. Зүрхээр хатгаж өвддөг эмгэг
 4. Миокардийн хүчилтөрөгчийн хэрэгцээ ихсэх
 5. Зүрхний судасны гаж хөгжил
- /202./ 38 долоо хоногтой жирэмсний үзлэг хийх зорилго нь юу вэ?
1. Төрөлтийн бэлтгэлийг үнэлэх
 2. Ургийн жинг тодорхойлох
 3. Нарийн мэргэжлийн эмч нарт үзүүлэх
 4. Төрөх газрыг товлох
 5. Эх барих эмэгтэйчүүдийн эмчид үзүүлэх
- /203./ “Шингэн их алдалттай суулгалт” гэж ангилагдсан 7 сартай 9 кг жинтэй хүүхдэд ямар хэмжээний рингер лактатын уусмалыг, хэрхэн дуслаар хийх вэ?
1. 6 цагийн турш 900 мл буюу 100 мл/кг жинд Рингер лактатын уусмал судсаар дусаана
 2. Эхний 1 цагт 270 мл буюу 30 мл/кг Рингер лактатын уусмал судсаар дусаана.
 3. Дараагийн 5 цагт 630 мл буюу 70 мл/кг Рингер лактатын уусмал судсаар дусаана
 4. Хүүхдийн биеийн жинг 75 мл-т үржүүлээд гарах хэмжээгээр шингэнийг судсаар дусаана
 5. 4 цагийн турш 120 мл/кг жинд тооцоолон дуслаар шингэн юүлнэ
- /204./ Ураг үхсэн байж болзошгүй тохиолдолд бага эмч ямар арга хэмжээ авах вэ?
1. Эмэгтэй болон нөхөрт нь хүүхэд үхсэн байж болзошгүйг мэдээлнэ
 2. Цус тогтоох эмчилгээ хийнэ
 3. Эмнэлэгт шилжүүлнэ
 4. Антибиотик тарина
 5. Өвдөлт намдаахаар морфин уулгана
- /205./ Хүмүүсийг нийгэм сэтгэцийн тулгамдсан асуудалтай болгодог сөрөг хүчин зүйлс:
1. Ядуурал
 2. Ажилгүйдэл
 3. Архидалт
 4. Хүчирхийлэл
 5. Гэр бүл салалт
- /206./ Томуу өвчин халуурах шалтгаан болж буйг ямар шинжүүдээр батлах вэ?
1. Толгой өвдөх
 2. Нүдний угруу өвдөх, гэрэлд нүд гялбах
 3. Хүүхэн хэл хөхөлбөр туяатай болж, ганц нэг цэгэн цусан тууралт ажиглагдах
 4. Ногоон цэртэй ханиах
 5. Гүйлсэн булчирхай улайж, хөөнгөтөж, идээлсэн байна
- /207./ ХӨЦМ-ийн дагуу “Ханиад шуухнаа” гэдэг ангилалтай хүүхдэд бага эмч ямар тусламж үзүүлэх вэ?
1. Халуун сүү, аарц уулгахыг зөвлөнө
 2. Чигатусин, читамон зэрэг хоргүй эмээр ханиадыг гэрээр эмчлэнэ
 3. 30-аас олон хоног ханиалгасан бол онош тодруулахаар хэвтүүлнэ
 4. Ямар шинж илэрвал яаралтай ирж үзүүлэхийг эхэд нь хэлнэ
 5. Хэрэв сайжрахгүй бол 5 хоноод давтан үзүүлэхийг зөвлөнө
- /208./ Сэтгэл түгшилтийг ихэсгэдэг органик шалтгаанууд:
1. Дотор муухайрах буюу бөөлжих
 2. Ураг тархины эмгэгүүд (тархины үрэвсэл, гэмтэл, хавдар)
 3. Ухаан балартах
 4. Амьсгалын дутагдалд хүргэдэг амьсгалын тогтолцооны эмгэгүүд
 5. Хорт хавдарын гаралтай хүчтэй өвдөлт
- /209./ 7 сартай, чихний цочмог халдвартай хүүхэд хөхөө өдөрт 5-6 удаа хөхдөг ба 2 удаа шингэн каш халбагаар иддэг. Хүүхэд өвчилж эхэлснээсээ хойш каша идэх дургүй болохоор

нь өгөхөө больсон. Одоо зөвхөн хөхөө хөхөж байгаа. Энэ хүүхдэд тохирох хооллолтын зөвлөгөө өг.

1. Хүссэн үед нь хөхүүлж бай

2. Каша өтгөн бэлтгэж өг (сүүгээр бэлтгэж, цөцгийн тос, шар тос, ургамлын тосны аль нэгийг, элсэн чихэр нэм)

3. Нэмэгдэл хоолны нэр төрлийг олшруул

4. Нэмэгдэл хоолны чанарыг сайжруул

5. Өвчтэй үед нь сайн хоолло

/210./ Цээжээр өвдөх нь зүрхний бах, шигдээсийн шалтгаантай болохыг ямар шинжүүдээр батлах вэ?

1. Өдвөлт зүүн гар, мөр рүү дамжих

2. Цээж давчин, агаар дутагдах, айдас төрөх

3. Зүрхний хэмнэл алдагдах, цусны даралт хэлбэлзэх

4. Өдвөлт баруун гар, мөр рүү дамжих

5. Гүн амьсгалах, ханиах үед өвдөлт ихсэх

/211./ Жирэмснээс хамгаалах дан прогестерон агуулсан эмийн ашигтай тал юу вэ?

1. Зөв хэрэглэсэн тохиолдолд 99% үр дүнтэй

2. Бэлгийн хавьталд нөлөө үзүүлэхгүй, саад учруулахгүй

3. Биений юмны мөчлөг тогмолжиж, бага хэмжээгээр, цөөн хоног, өвдөлтгүй ирдэг болно

4. Эмийг зогсооход жирэмслэх чадвар хурдан сэргэнэ

5. Умайн салстын болон өндгөвчний хорт хавдраас сэргийлнэ

/212./ Цус алдах үед бага эмч ямар тусламж үзүүлэх вэ?

1. Цусыг тогтоох физик, механик, биологийн аргуудаас боломжтойг нь ашиглах

2. Цусны бүлэгнэлтийг дэмжих Кальцийн бэлдмэл, викасол, аминакапроны хүчил зэрэг эмчилгээг хийнэ

3. Хаанаас алдаж байгаагаас хамааран хүйтэн жин тавих, мөс залгиулах, чангалуур, чихээс тавих зэрэг аргуудыг хэрэглэнэ

4. Өвчтөн ба гэр бүлийн гишүүдийг тайвшруулна

5. Цус алдалт зогсохгүй бол өвчтөнийг эмнэлэгт яаралтай хүргэж өгнө

/213./ Нарийн бүдүүн гэдэсний халдварт өвчин нь хэвлийгээр өвдөх шалтгаан болж байгааг ямар шинжүүдээр батлах вэ?

1. Суулгах шинж илрэх

2. Хэвлий нилэнхүйдээ өвдөх

3. Баасанд эмгэг хольц /язмаг, залхаг, ус, цус/ илрэх

4. Хараар баах

5. Цусанд диастаза ихсэх.

/214./ Эх барихын тусгайлсан асуумжаар дараах зүйлүүдийг тодруулна.

1. Жирэмслэлт, төрөлтийн тоо

2. Түрүүчийн жирэмслэлт, төрөлтийн явц. хүндрэл

3. Сүүлчийн сарын тэмдэг

4. Төрүүлсэн хүүхдийн жин, амьд эсэх, гарсан хүндрэл

5. Эх барихын ба эмэгтэйчүүдийн ямар нэг мэс ажилбар хийлгэж байсан эсэх

/215./ Төрсний дараа эхэд бага эмч ямар зөвлөгөө өгөх ёстой вэ?

1. Төрсний дараах үеийн тухай

2. Нярайн асаргааны тухай

3. Гэр бүл төлөвлөлтийн талаар

4. Төрөх үеийн өвдөлт бууруулах аргуудын тухай

5. Илүү тээлтийн тухай

/216./ 2 сартай хүүхдэд ямар вакцин хийх вэ?

1. Сахуу -хөхүүл ханиад-татрангийн эсрэг вакцин эсвэл 5-т вакцин

2. Саагийн эсрэг вакцин

3. В гепатитын вакцин

4. Улаанбурхан

5. Сахуу-татрангийн вакцин

/217./ “Завдсан зулбалт” гэдэг ангиллыг ямар шинжүүдийг үндэслэн тавьдаг вэ?

1. Үтрээнээс цус гарах ба үтрээний ялгадас эвгүй үнэртэй байх
 2. Үтрээнээс цус гарах ба умайд ажилбар хийж зулбуулсан.
 3. Үтрээнээс цус гарах ба хэвлийгээр өвдөх.
 4. Үтрээнээс бага зэрэг цус гарах
 5. Үтрээнээс цус гарах ба 38 хэмээс дээш халуурах
- /218./ Жирэмсэн эмэгтэй нийгмийн зүгээс ямар халамжийг авах эртэй вэ?
1. Жирэмсэн эмэгтэй хүнд хүчир ажил, шөнийн ээлжний ажлаас чөлөөлөгдөх эрхтэй.
 2. Хүүхдийн тоог, төрөлт хоорондын зайг өөрсдөө шийдвэрлэх эрхтэй
 3. Нэн ядуу, ядуу амьдралтай гэр бүлийн эх жирэмсний 5 сартайгаас эхлэн сар бүр 20000 төгрөг тогтмол авах эрхтэй
 4. Жирэмсэн эмэгтэй бүр сар бүр 50000 төгрөгний тэтгэмж авах эрхтэй
 5. Төрүүлсэн эх бүр сар бүр 50000 төгрөгний тэтгэмж авах эрхтэй
- /219./ Өвчтөн биохимийн ямар өөрчлөлтөөс болж амьсгаадаж болох вэ?
1. Уреми
 2. Чихрийн шижингийн ком
 3. Ацидоз
 4. Гипербилирубинеми
 5. Гипогликеми
- /220./ Бөөрний архаг дутагдлыг үүсгэдэг шалтгаануудыг нэрлэнэ үү?
1. Архаг гломерулонефрит
 2. Цусны даралт ихдэлт
 3. Архаг пиелонефрит
 4. Эмийн бодисын хордлого
 5. Чихрийн шижин
- /221./ 36 долоо хоногтой жирэмсэн эхэд ямар зөвлөгөө өгөх ёстой вэ?
1. Төмрийн бэлдмэл, фолийн хүчил уухын ач холбогдол, цус багадалт үүсч болох тухай.
 2. Хөх арчлах тухай
 3. Зулбалтаас сэргийлэх тухай
 4. Жирэмсний эмгэг байдал, түүнээс сэргийлэх тухай
 5. Жирэмслэлттэй холбоотой хууль зүйн ойлголт
- /222./ “Шингэн их алдалттай суулгалт” гэж ангилагдсан 1 нас 6 сартай 11 кг жинтэй хүүхдэд ямар хэмжээний рингер лактатын уусмалыг, хэрхэн дулаар хийх вэ?
1. 3 цагийн турш 1100 мл буюу 100 мл/кг жинд Рингер лактатын уусмал судсаар дусаана
 2. Эхний 30 минутанд 330 мл Рингер лактатын уусмал судсаар дусаана
 3. Дараагийн 2 цаг 30 минутанд 770 мл Рингер лактатын уусмал судсаар дусаана
 4. Хүүхдийн биеийн жинг 75 мл-т үржүүлээд гарах хэмжээгээр шингэнийг судсаар дусаана.
 5. 4 цагийн турш 120 мл/кг жинд тооцоолон дулаар шингэн юүлнэ
- /223./ Ураг үхсэн байж болзошгүйг ямар шинжүүдээр ангилах вэ?
1. Ураг хөдлөхгүй болох
 2. Ургийн байрлал хөндлөн болох
 3. Ургийн зүрхний цохилт сонсогдохгүй болох
 4. Төрөх үйл ажиллагаа эхлэхгүй байх
 5. Үтрээгээр цус гарах
- /224./ Сальмонеллэз өвчин халуурах шалтгаан болж буйг ямар шинжүүдээр батлах вэ?
1. Хий дүлүүлэлттэй , бага хэмжээтэй, уйланхай, цустай суулгах
 2. Хошноогоороо шээж буй мэт их хэмжээний усархаг шингэнээр суулгах.
 3. Хэвлийн доод хэсгээр базлуулж өвдөх
 4. Намгийн замгаг шиг ногоон язмагтай, усархаг зүйлээр суулгах
 5. Хараар суулгах
- /225./ ХӨЦМ-ийн дагуу “Ханиад шуухнаа” гэдэг ангиллыг бага эмч ямар шинжийг үндэслэн тавих вэ?
1. Ханиалгах
 2. Цээж хонхолзох
 3. Хамар битүүрч, шуухнах
 4. Хяхтнаа амьсгал

5. Амьсгал олшрох

/226./ Сэтгэл гутралыг бага эмч ямар эмээр эмчлэх вэ?

1. Имипрамин
2. Диазепам
3. Амитриптиллин
4. Лоразепам
5. Аминазин

/227./ 24 хоногтой нярайн арьсан дээр ганц нэг идээт цэврүү гарсан, өөр өвчний шинжгүй бол ХӨЦМ-ийн ямар агиллаар, ямар арга хэмжээ авах вэ?

1. Хэсэг газрын нянгийн халдвар гэж ангилна
2. Нянгийн хүнд халдвар байж болзошгүй гэж ангилна
3. Үүсгэгчийн эсрэг эм уулгаад, хэсэг газрын эмчилгээ хийгээд, 2 хоноод давтан үзнэ.
4. Антибиотикийн эхний тунг тариад, цусны сахар багасхаас сэргийлээд, дулаан авч явахыг зөвлөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.
5. Хүйний халдвар гэж ангилна

/228./ Жирэмснээс хамгаалах дааврын хавсарсан эмийг хэрэглэхийг хориглох заалт:

1. Жирэмсэн
2. Хөхүүл эмэгтэй төрсний дараах эхний 6 сарын дотор, хөхүүл биш нь төрсний дараа эхний 3 сарын дотор
3. Элэгний эмгэг, цусны даралт ихтэй ба цус өтгөрөх эмгэгтэй
4. Цус багадалт
5. Бэлгийн замын халдвар

/229./ Хамраас цус гоожих шалтгаан:

1. Гэмтэл
2. Артерийн даралт ихсэх
3. Тромбоцитопени
4. Хамрын хавдар буюу ур
5. Гемофили

/230./ Нойр булчирхайн үрэвсэл хэвлийгээр өвдөх шалтгаан болж байгааг ямар шинжүүдээр батлах вэ?

1. Өвдөлт хутгалах мэт хурц хүчтэй атлаа арагшаа нуруулуу дамжих
2. Хэвлийгээр бүслэх маягийн өвдөлт үүсэх
3. Цусанд диастаза ихсэх
4. Өвдөлт доошоо цавь, хярзан руу дамжих
5. Өвдөлт баруун мөр, гар руу дамжих

/231./ Хүнд тураалтай” гэж ангилагдсан хүүхдэд ямар шинжүүд илрэх вэ?

1. Хараажийн хүнд тураалын шинжүүд
2. Уураг дутагдлаас хоёр хөлөнд хавантай байх
3. Биеийн жин маш бага байх
4. Дагзны үс халцарсан
5. Булчин суларсан

/232./ Жирэмсэн эмэгтэйд жирэмслэлт, төрөлттэй холбоотой хууль зүйн ямар ойлголт өгөх вэ?

1. Хүн бүр нөхөн үржихүйн амьдралыг чөлөөтэй хянаж, таашаал авч байх эрхтэй ба албадан жирэмслэлт, үрийн суваг боолгох, үр хөндөлтөөс чөлөөтэй байх эрхтэй

2. Ямар ч эмэгтэй хүн нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж, энэ талаар мэдээлэл авч, боловсрол эзэмшиж, жирэмслэлтээ өөрөө зохицуулах эрхтэй

3. Эмэгтэй хүн бүр жирэмсэн буюу хүүхэд төрүүлсний улмаас нийгэм, ахуй, ажил эрхлэлтийн хүрээнд халамж үйлчилгээ авах эрхтэй ба ялгаварлан гадуурхагдах ёсгүй

4. Эмэгтэйчүүд шашин, ёс заншлаас ангид байж өөрийн бэлгийн болон нөхөн үржихүйн амьдралын талаар чөлөөт сонголт хийх эрхтэй

5. Хүн бүр гэрлэх, гал голомтоо бий болгох, төлөвлөх эрхтэй

/233./ Шингэн алдалттай суулгалтын шинжүүдийг заа:

1. Тайван биш, цочромтгой, цангасан, ховдоглон уух

2. Нүд хонхойх
 3. Арьсны хуниас удаан, 2 секундийн дотор арилах
 4. Унтаарсан, ухаангүй
 5. Ууж чадахгүй буюу уухдаа муудах
- /234./ Оюуны хомсдолтой өвчтөний гэр бүлийнхэнд өрхийн эмчийн зүгээс өгөх зөвлөмж:
1. Өөрийгөө арчлах дасгал сургуулилтыг байнга хийлгэж байх
 2. Бусдыг хайрлах, өрөвдөх харилцааг эзэмших чадвартай тул байнга дэмжиж байх
 3. Өвчтөний ололт амжилт, зүтгэлийг байнга урамшуулж байх
 4. Оюуны хомсдолтой хүүхдийг байнга хайр халамжаар хүмүүжүүлэх
 5. Оюуны хомсдлыг эмчлэх эмчилгээ байхгүй боловч амьдрах ур чадварыг эзэмшүүлэх нь түүнд ба гэр бүлд тустайг ойлгуулах
- /235./ 32 долоо хоногтой жирэмсэн эхэд ямар зөвлөгөө өгөх ёстой вэ?
1. Төмрийн бэлдмэл, фолийн хүчил уухын ач холбогдол, цус багадалт үүсч болох тухай.
 2. Төрөлтийн тухай
 3. Зулбалтаас сэргийлэх тухай
 4. Жирэмсний хожуу хордлого, түүнээс сэргийлэх тухай
 5. Жирэмслэлттэй холбоотой хууль зүйн ойлголт
- /236./ “Шигэн алдалтгүй, цусан суулгалттай” гэж ангилагдсан 4 настай хүүхдэд ямар тусламж үзүүлэх вэ?
1. Шингэн алдалтаас сэргийлж А төлөвлөгөөний дагуу эмчилнэ
 2. Үүсгэгчийн эсрэг эм 5 хоног уулгана
 3. 2 хоноод давтан үзүүлэхийг зөвлөнө
 4. 5 хоноод давтан үзүүлэхийг зөвлөнө
 5. В төлөвлөгөөний дагуу эмчилнэ
- /237./ Балнад өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?
1. Халдварын эх уурхайг эрт илрүүлж, дамжих замыг таслах
 2. Өвчтөнийг тусгаарлах, төгс эмчлэх
 3. Өвчтөнийг эдгэрэх явцад 5 өдрийн зайтай өтгөн, шингэнээс нян судлалын шинжилгээ авах, нян ялгаруулагсдыг диспансерын хяналтанд байлгах
 4. Хавьтагсдад нян залгиур уулгах
 5. Цэвэр усны эх үүсвэрийг ямагт чандлан хамгаалах
- /238./ Цусан суулгалт өвчин халуурах шалтгаан болж буйг ямар шинжүүдээр батлах вэ?
1. Хий дүлүүлэлттэй, бага хэмжээтэй, ойрхон уйланхай, цустай суулгах
 2. Хошноогоороо шээж буй мэт их хэмжээний усархаг шингэнээр суулгах
 3. Хэвлийн доод хэсгээр базлуулж өвдөх
 4. Намгийн замгаг шиг ногоон язмагтай, усархаг зүйлээр суулгах
 5. Хараар суулгах
- /239./ ХӨЦМ-ийн дагуу “Уушгины хүнд хатгалгаа” гэдэг ангиллыг бага эмч ямар шинжийг үндэслэн тавих вэ?
1. Цээж хонхолзох, ханиалгах
 2. Ямар нэг аюултай ерөнхий шинж илрэх
 3. Тайван үед хяхтнаж амьсгалах, ханиалгах
 4. Амьсгал олшрох, ханиалгах
 5. Шуугиант амьсгал
- /240./ Органик гаралтай сэтгэл гутарлын шалтгаан:
1. Дотоод шүүрлийн эмгэгүүд (микседема, Кушингийн хам шинж)
 2. Элэгний үрэвсэл, бруцеллёз зэрэг халдварт өвчнүүд
 3. Нойр булчирхай, мөгөөрсөн хоолойн хорт хавдрууд
 4. Паркинсоны өвчин
 5. Мэдэрлийн тэмбүү
- /241./ Цээжээр өвдөх шинж ямар өвчний үед илэрдэг вэ?
1. Зүрхний бах, зүрхний шигдээс
 2. Уушгины хатгалгаа, хуурай ба шүүдэст плеврит
 3. Уушгины хавдар, гялтангийн хавдар, голтын хавдар
 4. Цээжний ил, далд гэмтэл, хавирганы гэмтэл, хавирга хоорондын мэдрэлийн үрэвсэл

5. Хүзүү, сэрвээний остеохондроз, нурууны нугалмын шохойжилт, хавдар, гэмтэл, сүрьеэ /242./ Жирэмснээс хамгаалах дааврын хавсарсан эмийн сул тал юу вэ?

1. Дотор эвгүүрхэх, толгой өвдөх гаж нөлөө илэрч болно
2. Хөхөөр хөндүүрлэж болно
3. Биеийн жин бага зэрэг нэмэгдэж болно
4. Биений юм алдагдах, их хэмжээгаар ирэх болно
5. Цус багадалт үүсгэдэг

/243./ Бөөр, шээсний замаас цус алдах шалтгаан:

1. Бөөрний чулуу
2. Бөөрний хавдар
3. Бөөрний сүрьеэ
4. Бөөрний үрэвсэл
5. Бөөрний гэмтэл

/244./ Мухар олгойн үрэвсэл нь хэвлийгээр өвдөх шалтгаан болж байгааг ямар шинжүүдээр батлах вэ?

1. Хэвлийн баруун доод хэсгээр өвдөх
2. Хэвлийн зүүн доод хэсгээр өвдөх
3. Щёткин Блюмбергийн шинж эерэг болох
4. Өвдөлт зүүн мөр, гар руу дамжих
5. Аюулхай орчим төөнөх, хорсох маягаар өвдөх

/245./ Умайн хүзүүний бэлтгэлийн зэргийг дараах шинж чанараар илэрхийлдэг.

1. Умайн хүзүүний байрлал
2. Умайн хүзүүний сувгийн урт
3. Умайн хүзүүний амсрын хатуу зөөлөн
4. Умайн хүзүүний нээгдлийн хэмжээ
5. Умайн хүзүүний толийлт

/246./ Төрсний дараах үеийн тухай эхэд ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Төрсний дараа эх ариун цэврийг чанд сахих. Хүүхэд, хөх, өөрийн биеийг асрахын өмнө ба дараа гараа ямагт сайн угааж байх

2. Нярайг ба өөрийн биеийг дааруулахгүй байх

3. Нярай хүүхдэд хөхөө аль болох эрт амлуулах, хүссэн цагт нь хоногт 8-аас цөөнгүй хөхүүлж байх

4. Хөхүүл үед эх чанартай сайн хооллож байх ба хоногт 2 литрээс багагүй шингэн ууж байх

5. Прегнавит эсвэл Гентавит зэрэг жирэмсэн, хөхүүл эхчүүдэд зориулсан аминдэмийн бүрдлээс өдөр бүр нэг удаа ууж байх

/247./ Хараажийн хүнд тураалтай хүүхдэд ямар шинжүүд илрэх вэ?

1. Мөчид нарийсах
2. Хавирга хэрзийх
3. Илүүдэл өмөдний шинж
4. Хөлрөмтгий
5. Дагзны үс халцарсан

/248./ Ампициллин, Гентомицин зэрэг 2 антибиотикийг эмэгтэйд ямар заалтаар зэрэг хэрэглэдэг вэ?

1. Маш хүнд халууралт өвчнүүд
2. Шээсний дээд замын өвчин эсвэл уушгины хатгаа
3. Умайн болон ургийн халдвар

4. Төрсний дараах цус алдалт 24-өөс дээш цаг үргэлжилсэн эсвэл төрснөөс хойш 24 цагийн дараа цус алдсан

5. Хүндрэлтэй зулбалт, үр хөндөлт

/249./ Доод мөчний аль нэгэнд хаван үүсэх нь ямар шалтгаантай байж болох вэ?

1. Хэвлийн ба аарцгийн хөндийн хавдар өрөөсөн хөлний хураагуур судас дарах

2. Төрлөг ба хэвлийн хөндийн томоохон хагалгааны дараа хураагуур судсанд бөглөрөлт үүсэх

3. Удаан зогсдог ажилтай хүний доод мөчний хураагуур судас өргөссөнөөс хавагнах

4. Зүрхний дутагдал

5. Бөөрний дутагдал

/250./ Шингэн алдалтгүй суулгалттай 1 настай хүүхдэд ямар тусламж үзүүлэх вэ?

1. Гэрт нь А төлөвлөгөөний дагуу эмчлэнэ

2. Суулгалт бүрийн дараа 50-100 мл шингэн уулгана.

3. Хэзээ яаралтай үзүүлэхийг эхэд нь хэлээд, 5 хоноод давтан үзүүлэхийг зөвлөнө

4. Суулгалт бүрийн дараа 200 мл шингэн уулгана.

5. 4 цагийн турш 1 литр хорсол уулгана.

/251./ Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйд бага эмч ямар тусламж үзүүлэх ёстой вэ?

1. Ганцаарчилсан ярилцлага хийх, нууцыг хадгалахаа амлах

2. Тайвшруулах, өөртөө итгэлтэй болгох, туслах хүмүүс байгууллага байгааг сануулах

3. Үзлэг хийх, баримтжуулах, шинжилгээ авах

4. Хаанаас ямар тусламж авч болох талаар мэдээллээр хангах

5. Шаардлагатай бол биеийн ба сэтгэлийн эмгэгт эмчилгээ бичиж өгөх. Давтан үзлэг

товлох

/252./ 32 долоо хоногтой жирэмсэн эхэд ямар шинжилгээнүүд хийх ёстой вэ?

1. Цусны ерөнхий шинжилгээ, гемоглобины хэмжээ

2. Үтрээний наацын шинжилгээ

3. Шаардлагаар холбогдох шинжилгээг хийнэ

4. Шээсний ерөнхий шинжилгээ

5. Тэмбүүгийн сорил

/253./ Манас таталтын урьдлын хүнд хэлбэрийн үед бага эмч ямар тусламж үзүүлэх вэ?

1. Ачааллаа багасгахыг зөвлөнө

2. Долоо хоногийн дараа давтан үзүүлэхийг зөвлөнө

3. Долоо хоногийн дараа даралт их байвал эмнэлэгт хэвтүүлэхийг сануулна

4. Магнийн сульфат хийнэ, даралт бууруулах эм өгнө, эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ

5. Ампициллин тарина

/254./ Балнад өвчний үед ямар эмнэлзүйн шинжүүд илэрч болох вэ?

1. Бие сульдах, толгой өвдөх, шингэн баах, хоолны дуршилгүй болох

2. Өвчний ид үед халуун 39-40 хэм хүрч, халуун өдөр бүр давшингүй нэмэгдэх, ухаан

балартаж, дэмийрэх

3. Өвчний 8-10 дахь хоногт арьсан дээр цөөн тооны ягаан тууралт гарна

4. Биеэр цэврүүтэй олон тооны тууралт гарна

5. Хоёр хөлний шагай, өвдөгөөр жижиг цэгчилсэн цусан тууралт жигд гарна

/255./ Балнад өвчин халуурах шалтгаан болж буйг ямар шинжүүдээр батлах вэ?

1. Хэвлийгээр өвдөнө, суулгана

2. Цөөн тооны ягаан тууралт хэвлий дээр гарна

3. Халууралт өдөр бүр ихсэж, ухаан балартах, солиорох, дэмийрэх шинж илрэнэ.

4. Түгээмэл толбон гүвдрүүн тууралт дээрээсээ доошоо шаталж гарна.

5. Гүйлсэн булчирхай улайж, хөөнгөтөж, идээлсэн байна

/256./ Шуугиант амьсгал ямар эмгэгтэй хүүхдэд сонсогдох вэ?

1. Гуурсан хоолой бөглөрсөн

2. Гуурсан хоолой нарийссан

3. Багтраа өвчин

4. Уушгины хатгалгаа

5. Гялтангийн үрэвсэл

/257./ Хүйнээс нь идээ гарч байгаа, 2 өдөр халуурсан нярайд ХӨЦМ-ийн ямар ангиллаар, ямар тусламж үзүүлэх вэ?

1. Хэсэг газрын нянгийн халдвар гэж ангилна

2. Нянгийн хүнд халдвар байж болзошгүй гэж ангилна

3. Үүсгэгчийн эсрэг эм уулгаад, хэсэг газрын эмчилгээ хийгээд, 2 хоноод давтан үзнэ

4. Антибиотикийн эхний тунг тариад, цусны сахар багасхаас сэргийлээд, дулаан авч явахыг зөвлөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.

5. Хүйний халдвар гэж ангилна

/258./ Толгой өвдсөн өвчтөнд бага эмч ямар тусламж үзүүлэх вэ?

1. Шалтгааныг зөв тогтооно
2. Артерийн даралт ихэссэнээс толгой өвдсөн бол даралт бууруулах эмчилгээ хийнэ
3. Нүдний даралт ихэссэнээс толгой өвдсөн бол нүдний даралт бууруулна, нүдний эмчрүү яаралтай элгээнэ
4. Халууралттай халдварт өвчний улмаас толгой өвдсөн бол халуун бууруулах, өвдөлт намдаах парацетамол, аспирин, аналгин уулгана мөн үүсгэгчийн эсрэг эм хэрэглэнэ, халдварт өвчний менежментийн дагуу арга хэмжээ авна
5. Шалтгаан тодорхой бус толгой хүчтэй өвдөж, өвчтөний биеийн байдал маш хүнд байвал эмнэлэгт яаралтай хүргэж өгнө.

/259./ Жирэмснээс хамгаалах дааврын хавсарсан эмийн ашигтай тал юу вэ?

1. Зөв хэрэглэсэн тохиолдолд 99% үр дүнтэй
2. Бэлгийн хавьталд нөлөө үзүүлэхгүй, саад учруулахгүй
3. Биений юмны мөчлөг тогмолжиж, бага хэмжээгээр, цөөн хоног, өвдөлтгүй ирдэг болно
4. Эмийг зогсооход жирэмслэх чадвар хурдан сэргэнэ
5. Умайн салстын болон өндгөвчний хорт хавдраас сэргийлнэ

/260./ Хоол боловсруулах замаас цус алдах шалтгаан:

1. Улаан хоолойн судасны өргөсөлт
2. Улаан хоолой, ходоод, гэдэсний шархлаа
3. Улаан хоолой, ходоод, гэдэсний хавдар
4. Шамбарам
5. Шулуун гэдэсний цууралт

/261./ Үтрээний шинжилгээгээр дараах зүйлүүдийг тодорхойлно

1. Үтрээний хананы байдал
2. Умайн хүзүүний шинж чанар
3. Умайн хүзүүний гадна амсрын байдал
4. Түрүүлсэн хэсэг
5. Ургийн шингэний бүрхүүл хальсны байдал

/262./ Төрөх үеийн өвдөлтийг бууруулах аргуудын тухай бага эмч эхэд ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Төрөх явцад эмэгтэй айх, түгших, буруу дүлэх, тамир тэнхээгүй болох, төрөх үеийн сулрал үүсэх, өвдөлтийг хэт хүчтэй мэдрэх зэрэг сөрөг үр дагавартай байдаг тул төрөх үед биеэ зөв авч явах, төрөлтийн өвдөлт намдаах аргыг эзэмших хэрэгтэй

2. Төрлөгийн туршид тайван хэвтэх. Базлалтын үед гүнзгий жигд амьсгалах. Амьсгал авах, гаргах үедээ 2 гарын хуруугаар хэвлийн гол шугамаар умдагны дээрээс гадагш, дээш нь илэх

3. Умайн хүзүү бүрэн нээгдээгүй байхад хамаагүй дүлэх юм бол эхэс эрт ховхрох аюултайг анхааруулна

4. Ууц нурууны орчмыг атгасан гараар нухах
5. Ташаа, толгой орчимд нухахын зэрэгцээ ар нуруу чиглэлээр илэх.

/263./ “Чихний чочмог халдвартай” гэж ангилсан хүүхдэд ямар тусламж үзүүлэх вэ?

1. Өвдөлт намдаах ба чихээсээр чихийг цэвэрлэх эмчилгээ заагаад гэрээр эмчилнэ
2. Үүсгэгчийн эсрэг эм 5 хоног уулгана
3. 5 хоноод давтан үзүүлэхийг зөвлөнө
4. Үүсгэгчийн эсрэг эмийн эхний тунг өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.
5. Цусны сарах багасахаас сэргийлнэ

/264./ Ампициллиныг эмэгтэйд ямар заалтаар дангаар нь хэрэглэдэг вэ?

1. Ихэс, ихсийн хэсгийг гараар авсан
2. Төрөх үеийн үйл ажиллагаа эхлээд 24-өөс дээш цаг болсон
3. Умайн болон ургийн халдварын эрсдэлтэй
4. Маш хүнд халууралт өвчин
5. Хүндрэлтэй зулбалт, үр хөндөлт

/265./ Зулбалтаас сэргийлэхийн тулд ямар зөвлөгөөг жирэмсэн эмэгтэйд бага эмч өгөх ёстой вэ?

1. Зөв хооллож, ядрахгүй, хоногт 8 цагаас доошгүй унтах, сэтгэл санаагаар тайван байх

2. Тамхи, согтууруулах ундаа хэрэглэхгүй байх. Эмийг зөвхөн эмчийн зааврын дагуу хэрэглэх

3. Бэлгийн харьцааг цөөлөх, ялангуяа эхний 3 сар, сүүлийн 1 сард хориглох

4. Цэвэр, тохиромжтой, ялангуяа цээж, хэвлий бариагүй хувцас өмсөх. Өндөр өсгийтэй гутал өмсөхгүй байх

5. Жирэмсэн үед шөнийн жижүүр, хүнд хөдөлмөр, зогсоо ажил, доргио, халах, хөрөх, хими, туяаны нөхцөл, дуу шуугиан ихтэй ажил хийхгүй байх

/266./ Квинкийн хаван ямар онцлогтой вэ?

1. Хаван зөвхөн дээд мөчний нэг талд илрэх

2. Гэнэт нүүр, уруул, зовхи, хэл мэдэгдэхүйц хавагнах

3. Шээс ховордох

4. Хаван харшлын эсрэг эмчилгээнд хурдан бүр мөсөн арилна

5. Хаван зөвхөн доод мөчний нэг талд илрэх

/267./ 2 настай хүүхэд ханиалгасан, амьсгал нь 1 минутанд 52 болсон ба цээж нь хонхолзож байсан. Өөр эмгэг шинжгүй. Түүний амьсгал олширсон уу? Хэрхэн ангилах вэ?

1. Амьсгал олшроогүй

2. Амьсгал олширсон

3. "Ханиад шуухнаа" гэж ангилна

4. "Уушгины хүнд хатгалгаа" гэж ангилна.

5. "Уушгины хатгалгаа" гэж ангилна

/268./ Гэр бүлийн хүчирхийлэл нь яагаад эмэгтэйн эрүүл мэндэд хортойгоор нөлөөлдөг вэ?

1. Хүчирхийлэлд өртөж буй эмэгтэй сэтгэцийн асуудалтай (айдас, түгших эмгэг, сэтгэл гутрал, нойргүйтэх,) байдаг ба цаашид сэтгэцийн өвчинтэй болдог

2. Хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйд зүрх судасны өвчин, даралт ихсэх өвчин элбэг тохиолддог

3. Хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйд бамбай булчирхайн хордлого элбэг тохиолддог

4. Хүчирхийлэлд өртөж буй эмэгтэй богино насалдаг

5. Биеийн хүчирхийлэлд өртөж буй эмэгтэй гэмтэл авах, осолд орох, зулбах зэрэг нь элбэг байдаг

/269./ Ужиг суулгалттай хүүхдэд таргийг зөвлөдөг хэрнээ, сүүг яагаад зөвлөдөггүй вэ?

1. Тарганд лактобактер агуулагддаг тул ужиг суулгалттай хүүхдийн дисбактериозыг эмчилдэг

2. Тарганд сүүн хүчил агуулагддаг тул ходоодны хүчиллэг чанарыг сайжруулж хоолонд дуртай болгодог

3. Ужиг суулгалттай хүүхдийн гэдэсний өнгөр нимгэрч, лактазагийн дутагдалтай болдог тул лактозатай сүү суулгалтыг ихэсгэх аюултай

4. Тараг гэдсэнд өнгөр тогтоодог тул

5. Сүү гэдсэнд өнгөр тогтоодог тул.

/270./ Манас таталтын урьдлын хүнд хэлбэрийн үед ямар шинжүүд илэрдэг вэ?

1. Хоёр хэмжилтэнд сулралын даралт 90 МУБӨ, шээсэнд уураг 2+ ба толгой хүчтэй өвдөх, нүд бүрэлзэх, аюулхайд өвдөх шинжүүд илрэх

2. Шээсэнд давс ихээр илрэх.

3. Сулралын даралт 110 мм МУБӨ ба түүнээс их мөн шээсэнд уураг 3+

4. Сулралын даралт 80 мм МУБӨ

5. Шээсэнд лейкоцит ихээр илрэх

/271./ Менингококцемн үед илрэх үндсэн хам шинжүүдийг дурьдна уу

1. Хордлогын хам шинж (халуурах, хоол, нойронд муудах)

2. Менингитын хам шинж (Брудзинскийн шинжүүд эерэг болох)

3. Энцефалитын хам шинж (ухаан балартах, солиорох)

4. Цусан тууралтын хам шинж (улаан гүвдрүүт тууралт, цусан тууралттай хавсран илэрч болно)

5. Хамар залгиурын үрэвслийн хам шинж (залгиурын арын хана улайж, хөхлөгүүд тодорсон байна, нусгайрна)

/272./ Улаанууд өвчин халуурах шалтгаан болж буйг ямар шинжүүдээр батлах вэ?

1. Жижиг зангилаат улаан тууралт нуруу, өгзөг, биеийн арын хэсгээр шигүүрэх хандлагатай биеэр гарна
2. Халууралт ба тууралт нь нэгээс хоёр хоногийн дотор ямар ч эмчилгээгүй арилна
3. Дагзны буюу хүзүүний арын булчирхай томрох хандлагатай
4. Түгээмэл толбон гүвдрүүн тууралт дээрээсээ доошоо шаталж гарна
5. Жижиг зангилаат тууралт бүх биеэр гарна, биеийн дотор буюу хэвлийн доод хэсгээр шигүүрэх хандлагатай, ам, хамрын гурвалжин цэвэр байна

/273./ Сэтгэл гутралын эмнэлзүйн шинжүүд:

1. Тодорхой шалтгаангүйгээр гуниглах, гутрах, сэтгэлээр унах
2. Өвчтөний зовхи буух, дух үрчлээтэх, царай гунисан байдалтай харагдах, хөдөлгөөн удааширдаг
3. Өвчтөн удаан сэтгэж, нам дуугаар, цөөн үгээр ярьдаг, давтан асуултанд нэг үгээр хариулдаг
4. Орчинд буй зүйл, үйл явдал сэтгэл хөдлөгдөггүй бөгөөд хооллох ба бэлгийн дур буурдаг
5. Өвчтөний зориг эрмэлзэл, дур хүсэл, сонирхол, хэрэгцээ, идэвхи, санаачлага буурдаг тул амьдрах сонирхолгүй болж өөрийгөө арчлан сувилахаа больдог

/274./ Ямар хүүхдийн хооллолтыг үнэлэх ёстой вэ?

1. Цус багадалттай хүүхдийн
2. Тураалтай хүүхдийн
3. Тураалгүй, цус багадалтгүй ч 2 хүртэлх насны бүх хүүхдүүдийн
4. 1-5 хүртлэх насны бүх хүүхдүүдийн
5. Рахиттай хүүхдийн

/275./ Толгой өвдөж буй өвчтөнд хүзүүний остеохондроз байж болзошгүйг ямар шинжүүдээр батлах вэ?

1. Толгойгоо урагшаа тонгойлгон эгмэндээ хүргээд, дараа нь арагшаа болгоомжтой гэдийхэд өвдөх.
2. Толгойгоо баруун, зүүн тийш хазайлган, чихээ мөрөндөө хүргэхийг хичээхэд хүзүүгээр өвдөх
3. Толгойгоо аажим эргүүлж, арагшаа харахыг хичээхэд тог гүйх мэт өвдөх.
4. Халуурах
5. Дагзны булчин хөшингө болох

/276./ Нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр бага эмч ямар ажил хийх ёстой вэ?

1. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн жирэмслэлт, төрөлт, нярай хүүхдийн эрүүл мэндийн бүртгэл хийх
2. Жирэмснийг эрт илрүүлэх
3. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт жилд 2- оос доошгүй удаа оруулах
4. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг эрүүлжүүлэх ажил хийх
5. Үйлчлэх хүрээний нутаг дэвсгэртээ эрүүл мэндийн идэвхтэнг сургаж, үйл ажиллагаандаа туслуулах

/277./ Элэгний үрэвсэл хэвлийгээр өвдөх шалтгаан болж байгааг ямар шинжүүдээр батлах вэ?

1. Хурц биш атлаа унжих, цанхайх маягаар өвдөх
2. Элэг томрох шинж тэмтрэлтээр илрэх
3. Өвдөлт баруун мөр, гар руу дамжих
4. Өвдөлт доошоо цавь, хярзан руу дамжих
5. Өвдөлт зүүн мөр, гар руу дамжих

/278./ Тархины судасны хатуурлын үед ямар шинжүүд илрэх вэ?

1. Юм мартах, толгой эргэх
2. Нойргүйдэх
3. Сэтгэл санаа тогтворгүй болох
4. Чих шуугих
5. Нүдний хараа муудах

/279./ 38 долоо хоногтой жирэмсэн эхэд төрөлтөнд бэлтгэх тухай ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Төрөлтийн үйл ажиллагаа товлосон хугацаанаас 14 хоногийн наана, эсвэл 7 хоногийн цаана эхэлж болно

2. Төрөх үйл ажиллагаа хэдийд ч эхэлж болзошгүй тул одооноос хөдөө, зуслан зэрэг унаа муутай хол газар аялалаар, ажлаар явах хэрэггүй

3. Төрөх үйл ажиллагаа эхэлмэгц төрөх газар очих хэрэгтэй

4. Төрөх газар очихын өмнө иргэний үнэмлэх, гар карт, цэвэр дотуур хувцас, унтлаганы хувцас, амны хаалт, ариун цэврийн хэрэглэл, төрсний дараа өмсөх халат эсвэл тэрлэг зэрэг ойр зуурын зүйлээ бэлдсэн байх хэрэгтэй

5. Төрөх явцад ядарч тамирдахгүйн тулд чихэртэй хар цай, алим, шоколад авч явж болно /280./ Төмрийн фолатыг жирэмсэн эх уухад ходоод өвдөх хандлагатай байвал бага эмч ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Төмрийн фолатыг хоол идсэний дараа аскорбины хүчлээр ба ихээхэн шингэнээр даруулж уухыг хичээ

2. Хэрэв энэ эм таалагдахгүй, уухад хэцүү байвал эмийн сангаас прегнавит гэдэг эмийг авч уух хэрэгтэй

3. Прегнавитыг жирэмсний эхний 3 сард хоногт 1 ширхэгээр, хоёрдох 3 сард хоногт 2 ширхэгээр, 3 дахь 3 сард хоногт 3 ширхэгээр ууна

4. Хэрэв төмрийн фолат жирэмсэн эхэд таалагдахгүй байвал өөр эм орлуулан уух хэрэггүй.

5. Төмрийн фолат жирэмсэн эхийн ходоодыг өвтгөж байсан ч уух хэрэгтэй /281./ Бөөрний дутагдлаас үүсэх хаван ямар онцлогтой вэ?

1. Хаван зөвхөн дээд мөчний нэг талд илрэх

2. Шээс ховордох

3. Хаван өглөө багасах, орой ихсэх, хөлөөр илүүтэй гарах хандлагатай

4. Хаван өглөөгүүр нүүр, зовхиор илүүтэй гарч, орой багасах хандлагатай

5. Хаван зөвхөн доод мөчний нэг талд илрэх

/282./ 32 долоо хоногтой жирэмсэн эхийн үзлэгээр юу хийх ёстой вэ?

1. Эрүүл мэндийн талаар асуумж авах, биеийн үзлэг хийх

2. Ургийн байрлал, түрүүлсэн хэсэг, янзыг тогтоох

3. Ургийн зүрхний цохилтыг сонсох

4. Дотуур үзлэх хийх

5. Дотуур ЭХО хийх

/283./ Ужиг суулгалттай хүүхдэд өгөх хооллолтын зөвлөгөө

1. Насанд нь тохирсон хоолыг өгнө, хүссэн цагт нь хөхүүлэх

2. Шинэхэн бүрсэн тараг шүүж уулгах

3. Сүү уудаг бол түүнийг нь хасах эсвэл цагаан будааны шүүсээр 2 дахин шингэлэх

4. Хоолыг сойх

5. Нэмэлт хоолыг нь хасаад зөвхөн үнээний сүү уулгах.

/284./ Манас таталтын урьдал үедийн шинжүүд илэрсэн жирэмсэн эхэд бага эмч ямар тусламж үзүүлэх вэ?

1. Ачааллаа багасгахыг зөвлөнө

2. Долоо хоногийн дараа давтан үзүүлэхийг зөвлөнө

3. Долоо хоногийн дараа даралт их байвал эмнэлэгт хэвтүүлэхийг сануулна

4. Эмнэлэгт хэвтүүлнэ

5. Магнийн сульфат хийнэ

/285./ Бруцеллёзыг ямар өвчинтэй ялган оношлогоо хийх ёстой вэ?

1. Балнад

2. Хумхаа

3. Лимфогрануломатоз

4. Сүрьеэ

5. Хэрх өвчин

/286./ Хүүхдэд цээж хонхолзох шинж илэрч байвал бага эмч ямар арга хэмжээ авах вэ?

1. Гараа эмчилгээнд үүсгэгчийн эсрэг эмийн эхний тунг уулгана

2. Гараа эмчилгээнд цусны сахар багсахаас сэргийлнэ

3. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ

4. Утлага хийж гэрээр эмчлэнэ.
5. Хөлийг гичтэй усанд дүрж гэрээр эмчилнэ

/287./ Сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх явцад багийн бага эмч ямар шаардлагыг хангах ёстой вэ?

1. Өвчтөний нэр төрийг хамгаалж, өвчтөний нууцыг хадгалах
2. Сэтгэцийн хямралтай тэмцэх арга барилд өвчтөн болон гэр бүлийнхнийг сургах
3. Нийтээр хэвшсэн хэ м хэмжээний дагуу биеэ авч явах арга барилд сургах
4. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн заалтыг баримталж ажиллах
5. Сэтгэцийн өвчний хүндрэлтэй тэмцэх арга барилд өвчтөн болон гэр бүлийнхнийг сургах

/288./ “Хэсэг газрын нянгийн халдвар” гэж ангилагдсан нярайд ямар тусламж үзүүлэх вэ?

1. Үүсгэгчийн эсрэг тохирох эмийг гэрээр уулгана
2. Хэсэг газрын халдварыг эмчлэхийг эхэд зааж сургана
3. 2 хоноод давтан үзүүлэхийг зөвлөнө
4. Антибиотикийн эхний тунг булчинд тарина
5. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ

/289./ Толгой өвдөж буй өвчтөнд халдварт өвчин байж болзошгүйг ямар шинжүүдээр батлах вэ?

1. Халуурах ба халдвар хордлогын шинжүүд /хоол, нойронд муудах/
2. Артерийн даралт ихсэх
3. Халдварт өвчний өвөрмөц шинжүүд /тууралт, ханиах, нус гойжих, хоолой идээлэх, суулгах, бөөлжих/
4. Хараа огцом муудах
5. Хүзүүгээ хөдлөгөхөд тог гүйж буй мэт өвдөх

/290./ Уушгинаас цус алдах шалтгаан:

1. Уушгины хавдар
2. Уушгины сүрьеэ
3. Уушгины идээт өвчнүүд
4. Уушгины артерийн тромбоз
5. Уушгины гэмтэл

/291./ Ходоод, 12 хуруу гэдэсний үрэвсэл хэвлийгээр өвдөх шалтгаан болж байгааг ямар шинжүүдээр батлах вэ?

1. Аюулхай орчим төөнөх, хорсох маягаар өвдөх
2. Өвдөлт арагшаа нуруулуу дамжих
3. Өвдөлт хооллолттой холбоотой сэдрэх
4. Өвдөлт баруун мөр, гар руу дамжих
5. Өвдөлт доошоо цавь, хярзан руу дамжих

/292./ Бөөрний архаг дутагдлын үед зайлшгүй хийгдэх шинжилгээ юу вэ?

1. Шээсний нянгийн шинжилгээ
2. Цусны электролитыг үзэх
3. Цусны PH үзэх
4. Цусан дахь креатинины хэмжээг тодорхойлох
5. Бөөрний рентген зураг авах

/293./ 38 долоо хоногтой жирэмсэн эхэд төрөх үйл ажиллагааны тухай бага эмч ямар зөвлөгөө өгөх ёстой вэ?

1. Төрөлтийн үйл ажиллагаа товлосон хугацаанаас 14 хоногийн наана, эсвэл 7 хоногийн цаана эхэлж болно
2. Төрөхөөс өмнө салиархаг зүйл үтрээнээс гарч болно
3. Гэдэс дуншиж өвдөх нь эхлээд хэдэн цагийн зайтай байснаа хоорондох зай нь ойртох болно. Энэ нь төрөх үйл ажиллагаа эхэлсэн шинж
4. Дуншиж өвдөсний дараа хүчтэй базлуулж, дүлүүлж өвдөнө
5. Төрөх үйл ажиллагаа эхэлмэгц төрөх газар очих хэрэгтэй

/294./ Хүнд тураалтай 3 сартай хүүхдэд ямар тусламж үзүүлэх вэ?

1. А аминдэмийн 50000 нэгжтэй цагаан капсулаас 1 ширхэгийг уулгана
2. Цусны сахар багасхаас сэргийлнэ
3. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ

4. А аминдэмийн 100000 нэгжтэй хөх капсулаас 1 ширхэгийг уулгана
 5. А аминдэмийн 200000 нэгжтэй улаан капсулаас 1 ширхэгийг уулгана.
- /295./ Төрсөн эхэд ямар шинж илэрвэл яаралтай тусламж хэрэгтэй вэ?
1. Ухаангүй эсвэл татах
 2. Цус алдаж байгаа эсвэл хэвлийгээр хүчтэй өвдөх
 3. Толгой өвдсөн эсвэл нүдний харах байдал өөрчлөгдөх
 4. Маш их бэрхшээлтэй амьсгалах эсвэл халуурах
 5. Их хэмжээгээр бөөлжих
- /296./ Төмрийн бэлдмэлийг эмэгтэйд уулгахдаа ямар зөвлөгөө өгөх вэ?
1. Төмрийн бэлдмэл нь цус багадалтыг эмчилдэг тул эрүүл мэндэд хэрэгтэй
 2. Төмрийн бэлдмэлийг хоол идсэний дараа орой бүр ууж байх хэрэгтэй
 3. Баас хар гарвал санаа зовох хэрэггүй
 4. Төмрийн бэлдмэлийг ууснаар аргах шинж илэрвэл шингэн ихээр уух хэрэгтэй
 5. Төмрийн бэлдмэлийг ууснаар зовиур ихээр илэрвэл эмчилгээг зогсоож болно
- /297./ Зүрхний дутагдлаас үүссэн хаван ямар онцлогтой вэ?
1. Зүрхний цохилт олшрох, хэм алдагдах шинж илрэх
 2. Амьсгаадах, хөхрөх шинж илрэх
 3. Хаван өглөө багасах, орой ихсэх, хөлөөр илүүтэй гарах хандлагатай
 4. Хаван өглөөгүүр нүүр зовхиор илүүтэй гарч, орой багасах хандлагатай
 5. Хаван зөвхөн доод мөчний нэг талд илрэх
- /298./ 3 сартай хүүхэд ханиалгаж байгаа ба түүний амьсгал 1 минутанд 48 байна. Өөр эмгэг шинжгүй. Түүний амьсгал олширсон уу? Хэрхэн ангилах вэ?
1. Амьсгал олшроогүй
 2. Амьсгал олширсон
 3. "Ханиад шуухнаа" гэж ангилна
 4. Уушгины хатгалгаа" гэж ангилна.
 5. "Уушгины хүнд хатгалгаа" гэж ангилна
- /299./ Гэр бүлийн хүчирхийлэл нь яагаад хүүхдийн эрүүл мэндэд хортой нөлөөлдөг вэ?
1. Хүчирхийллийг харж буй хүүхэд аймхай, хулчигар болдог ба сэтгэл санааны хувьд хүнд шархтай байдаг
 2. Хүчирхийлэлд өртөж буй хүүхэд ээрүү, нүд анивчдаг, орондоо шээдэг болдог
 3. Хэрүүл зодоонтой гэр бүлд амьдардаг хүүхэд эцэг эхээсээ ичихдээ ганцаардмал, аутизмтай болдог
 4. Эцэг эхдээ зодуулдаг хүүхэд бэртэл, гэмтэл авсан ч хагас дутуу эмчлүүлдэг эсвэл эмчлүүлдэггүй
 5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй орчинд өссөн хүүхэд эргээд хүчирхийлэгч болох магадлал өндөр байдаг
- /300./ 32 долоо хоногтой жирэмсэ эхийн үзлэг хийх зорилго нь юу вэ?
1. Жирэмсний явц, эмгэг байдлыг үнэлэх
 2. Ургийн өсөлт, хөгжлийг үнэлэх
 3. Шаардлагатай бол нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөгөө авах
 4. Эх барихын мэргэжлийн эмчийн зөвлөгөө авах
 5. Төрөхийн өмнөх амралт олгох
- /301./ "Шингэн алдалтгүй, ужиг суулгалт" гэж ангилагдсан 2 настай хүүхдэд ямар тусламж үзүүлэх вэ?
1. Шингэн алдалтаас сэргийлж А төлөвлөгөөний дагуу эмчилнэ
 2. Зөв хооллох талаар эхэд зөвлөнө
 3. Мультивитамин 14 хоног уулгана
 4. Хэзээ яаралтай ирэхийг зөвлөнө
 5. 5 хоноод давтан үзүүлэхийг зөвлөнө
- /302./ Манас таталтын урьдал үед ямар шинжүүд илэрдэг вэ?
1. Хоёр хэмжилтэнд сулралын даралт 90-110 мм МУБӨ
 2. Шээсэнд уураг илрээгүй
 3. Шээсэнд уураг 2+
 4. Сулралын даралт 80 мм МУБӨ бага.

5. Шээсэнд лейкоцит их.
- /303./ Улаан эсэргэн өвчин халуурах шалтгаан болж буйг ямар шинжүүдээр батлах вэ?
1. Жижиг зангилаат тууралт бүх биеэр гарна, хэвлийн доод хэсгээр шигүүрэх хандлагатай, ам, хамрын гурвалжин цэвэр байна.
 2. Хоолой тод заагтай улайж үрэвсэнэ
 3. Эрүүн доорхи буюу хүзүүний урд талын тунгалгийн булчирхай томорч цочирно
 4. Түгээмэл толбон гүвдрүүн тууралт дээрээсээ доошоо шатлаж гарна
 5. Ханиах, нус гойжих, нүд улайх шинжийн аль нэг илэрч болно
- /304./ Хүүхдэд цээж хонхолзох шинжийг тодорхойлох зөв хариултуудыг сонго.
1. Амьсгал авах үед цээжний доод хэсэг дотогш татагдах
 2. Амьсгал гаргах үед цээжний доод хэсэг дотогш татагдах
 3. Тайван үед, тогтмол ажиглагдана
 4. Зөвхөн хөхөө хөхөх, уйлах үед цээжний доод хэсэг дотогш татагдах
 5. Амьсгал авахад эгэмний хонхор татагдана
- /305./ Сэтгэцийн эрүүл мэндийн анхдагч түвшний боловсрол олгох гэж юуг хэлдэг вэ?
1. Сэтгэц нийгмийн тулгамдсан асуудлаа ухаалаг шийдвэрлэх мэдлэг, чадвартай болгох
 2. Стресс тайлах ур чадварыг эзэмшүүлэх
 3. Эрүүл ба эрүүл бус зан үйлийн тухай зохих мэдлэгтэй болгох
 4. Архи, тамхинд уруу татах найз нөхдийн шахалтанд өртөхгүй байх ур чадвар эзэмшүүлэх
 5. Өөрийнхөө үнэт чанарыг зөв үнэлэх ба бусадтай зөв харилцах ур чадварыг эзэмшүүлэх
- /306./ “Нянгийн хүнд халдвар байж болзошгүй” гэж ангилагдсан нярайд ямар тусламж үзүүлэх вэ?
1. Эмнэлэгт хэвтүүлэх шаардлагатайг эхэд нь тайлбарлана
 2. Антибиотикийн эхний тунг булчинд тарина
 3. Цусны чихэр багасахаас сэргийлнэ
 4. Замдаа хүүхдээ дулаан авч явахыг зөвлөнө
 5. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
- /307./ Умайн ерөндөгийн сул тал юу вэ?
1. Биений юм элбэгших, удаан хугацаагаар өвдөлттэй ирэх магадлалтай
 2. Бэлгийн замын халдвараас хамгаалахгүй
 3. Бага аарцгийн үрэвсэл үүсгэж болзошгүй
 4. Хөхний сүүний гарц, чанарыг багасгадаг
 5. 1 жил жирэмснээс хамгаалдаг
- /308./ Хэвлийгээр өвдөх шинж ямар өвчин эмгэгийн үед илрэх вэ?
1. Аюулхай орчим өвдөх нь гол төлөв ходоод, 12 хуруу гэдэс, өрц, улаан хоолойн доод хэсгийн өвчин байж болно
 2. Баруун талын хавирганы нумын доогуур өвдөх нь элэг, цөсний хүүдий, цөсний гол цорго, нойр булчирхайн толгой хэсэг, 12 хуруу гэдэс, баруун бөөрний өвчин байж болзошгүй.
 3. Хэвлийн баруун доод хэсгээр өвдөх нь мухар олгойн үрэвсэл, цутгалан гэдэсний үрэвсэл, баруун өндгөвч, шээлэйн өвчин, цавины ивэрхий зэрэг байж болзошгүй.
 4. Хэвлийн зүүн доод хэсгийн өвдөлт нь тахир гэдэс, зүүн талын өндгөвч, шээлэйн өвчин, цавины ивэрхий зэрэг байж болзошгүй
 5. Хүйсний орчим өвдөх нь нарийн гэдэс, чацархайн судас, булчирхай, сэмж, мэдэрлийн наран сүлжээ зэргийн өвчин байж болзошгүй
- /309./ Эрүүл хүүхдэд А аминдэмийг хэрхэн уулгах вэ?
1. 6 сараас 5 нас хүртэл 6 сар тутамд нэг тунг уулгана
 2. 6 сартай хүүхдэд 100000 нэгжээр уулгана
 3. Нэгээс 5 нас хүртэл 6 сар тутам 200000 нэгжээр уулгана
 4. 1-2 нас хүртэл 100000 нэгжээр уулгана
 5. 6 сартай хүүхдэд 50000 нэгжээр уулгана
- /310./ “Умайн ба ургийн халдварын эрсдэлтэй” гэсэн ангилалтай эмэгтэйд ямар тусламж үзүүлэх вэ?
1. Тохирох антибиотикийг тарина
 2. Антибиотик уулгана
 3. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.

4. Төрөх үйл ажиллагаа эхэлсэн эмэгтэйтэй адил арга хэмжээ авна

5. Ношпа уулгана

/311./ Жирэмсэн эмэгтэй фолийн хүчил яагаад уух ёстой вэ?

1. Эмэгтэй давхар биетэй болсоноор шим тэжээлт хоолны хэрэгцээ, ялангуяа төмөр, фолийн хүчлийн хэрэгцээ ихэсдэг

2. Фолийн хүчил нь төрөх үеийн цус алдалтаас сэргийлдэг

3. . Фолийн хүчил нь ургийн эд эсийн төлжилт бойжилтыг хэвийн явуулдаг. Фолийн хүчил дутагдахад урагт гаж хөгжил үүсэх аюултай

4. Фолийн хүчил нь төрөх үеийн сулралаас сэргийлдэг

5. Фолийн хүчил нь жирэмсний хордлогоос сэргийлдэг

/312./ Гэр бүлийн хүчирхийлэл нь гэр бүлийн хэрүүл маргаанаас юугаар ялгаатай вэ?

1. Нэг нь дийлж, нөгөө нь буруутай, айдастай үлддэг

2. Хоёулаа ижил хэрэлдэж, маргалдаж, тэгш эрхтэй тэмцдэг

3. Асуудал бүрэн шийдвэрлэгдэхгүй, дараа дахин давтагдах магадлалтай байдаг

4. Асуудлыг шийдвэрлэж, хоёул буруугаа ойлголцдог

5. Бие биенээсээ нуух, хаацайлах зүйл байдаггүй

/313./ 28 долоо хоногтой жирэмсэн эхэд ямар шинжилгээнүүд хийх ёстой вэ?

1. Чанд авианы шинжилгээ

2. Үтрээний наацын шинжилгээ

3. Шаардлагаар холбогдох шинжилгээг хийнэ

4. Цус, шээсний ерөнхий шинжилгээ

5. Флюорографи.

/314./ Бруцеллёзоос урьдчилан сэргийлэхийн тулд бага эмч ямар арга хэмжээ авах вэ?

1. Мал, амьтадтай ажилладаг хүмүүс хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлийг өмсөх талаар зөвлөх

2. Мах, сүү, цагаан идээг сайн боловсруулж хэрэглэхийг зөвлөх

3. Шинжилгээ хийлгээгүй малын сүү, өрөм, тос, мах худалдан авах ба хэрэглэхээс болгоомжлохыг зөвлөх

4. Донорын цусанд шинжилгээ хийлгэхийг зөвлөнө

5. Амьсгал дуслын замаар халдварладаг тул амны хаалт хийхийг зөвлөнө

/315./ Хяхтнаа амьсгал илэрсэн хүүхдэд бага эмч хэрхэн туслах вэ?

1. Гараа эмчилгээнд үүсгэгчийн эсрэг эмийн эхний тун, сальбутамол тохирох тунгаар уулгана

2. Гараа эмчилгээнд цусны сахар багсахаас сэргийлнэ

3. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ

4. Утлага хийж гэрээр эмчлэнэ

5. Хөлийг гичтэй усанд дүрж гэрээр эмчилнэ

/316./ Толгой өвдөж буй өвчтөнд нүдний даралт ихэссэн байж болзошгүйг ямар шинжүүдээр батлах вэ?

1. Нүдний ухархайгаар хүчтэй өвдөх

2. Хараа огцом муудах

3. Юмс солонгорж харагдах

4. Хүзүүгээр урагш, хойш, хажуу тийш хөдлөгөхөд тог гүйж буй мэт өвдөх

5. Дагзны булчин хөшингө болох

/317./ Умайн ерөндөгийн ашигтай тал юу вэ?

1. Удаан хугацаагаар жирэмслэлтээс хамгаална. Цэвэрших хүртэл хэрэглэж болно.

2. Төрсний болон үр хөндүүлсний дараа шууд тавьж болно

3. Хөхний сүүний гарц, чанарт нөлөөлөхгүй

4. Бэлгийн замын халдвараас сэргийлнэ

5. Умайн цус алдалтыг багасгана

/318./ Шарлалттай өвчтөнд бага эмч ямар тусламж үзүүлэх вэ?

1. Гемодез дуслаар хийнэ

2. Шалтгааныг тогтоож, халдварт шар бол халдвар хамгааллын дэглэмийг сахина

3. Эссенциал уулгана

4. Эмнэлэгт хойшлуулахгүй хүргэж өгнө

5. Лив 52 уулгана

/319./ Цээжээр өвдөх шинжтэй өвчтөнд бага эмч ямар менежмент хийж, хэрхэн туслах вэ?

1. Өвдөлтийн шалтгааныг яаралтай тогтооно

2. Зүрхний шалтгаанд өвдөлт гэж үзвэл нитроглицерин, валидол, аналгин хэрэглээд, өвчтөнийг тайвшруулаад 15 минут ажиглана. Өвдөлт намдахгүй бол эмнэлэгт хэвтүүлэх

3. Хавирганы мэдэрлийн үрэвсэл, хавирга гэмтсэн үед өвдөлт намдаах эм хэрэглэх, гич наах, өвдөлт намдаах

тууз наах, бумба, бэгнүүр тавих. Уушгины эмгэгээс шалтгаалж цээж өвдөж байвал гэрэлд харуулах, үүсгэгчийн эсрэг эм хэрэглэх, дотрын эмчид үзүүлж заалтыг биелүүлэх

4. Зүрхний шигдээс өвдөлтийн шалтгаан гэж үзвэл нитроглицерин, аналгин, димедрол тариад гэрээр эмчлэх.

5. Зүрхний бах цээжний өвдөлтийн шалтгаан гэж үзвэл эмнэлэгт яаралтай хэвтүүлэх.

/320./ Зүрхний шигдээсийн үед ямар арга хэмжээ авах вэ?

1. Хэвтрийн хатуу дэглэм сахиулах

2. Өвчин намдаах эмчилгээ

3. Хүчилтөрөгч эмчилгээ

4. Гепарин эмчилгээ

5. Аспирин

/321./ Дутуу төрөлтөөс сэргийлэхийн тулд ямар зүйлийг анхаарах ёстой вэ?

1. Зөв хооллож, ядрахгүй, хоногт 8-аас доошгүй цаг унтах, сэтгэл санаагаар тайван байх. Зөвхөн эмчийн зааврын дагуу эмийг хэрэглэх

2. Жирэмсний хожуу үеийн хордлогоос сэргийлэх

3. Бэлгийн харьцааг цөөлөх, ялангуяа эхний 3 сар, сүүлийн 1 сард хориглох

4. Цэвэр, тохиромжтой, ялангуяа цээж, хэвлий бариагүй хувцас өмсөх. Өндөр өсгийтэй гутал өмсөхгүй байх

5. Жирэмсэн үед шөнийн жижүүр, хүнд хөдөлмөр, зогсоо ажил, доргио, халах, хөрөх, хими, туяаны нөхцөл, дуу шуугиан ихтэй ажил хийхгүй байх.

/322./ “Халууралт. Нүд буюу амны хүндрэлтэй улаанбурхан” гэж ангилагдсан хүүхдэд ямар тусламж үзүүлэх вэ?

1. А аминдэм өгнө

2. Тетрациклины тосоор нүдний халдварыг эмчилнэ

3. Амны шархлааг генцианвиолетээр эмчилнэ

4. 2 хоноод давтан үзүүлэхийг зөвлөнө

5. 38,5 хэмээс дээш халуурвал парацетамолыг 6 цагаар уулгана.

/323./ Тэмбүүтэй эмэгтэйд ямар эмчилгээ хийх вэ?

1. Бензатилпенициллин G 2,6 саяаар тарина

2. Циплофлоксацин 500 мг нэг удаа уух

3. Доксациклин 100 мг-аар өдөрт 2 удаа 7 хоног уух эсвэл Эритромицин 500 мг-аар өдөрт 4 удаа уух

4. Цефтриаксон 250 мг булчинд нэг удаа тарих.

5. Метронидазол 2 гр нэг удаа уулгах эсвэл Метронидазол 400-500 мг өдөрт 2 удаа 7 хоног уух.

/324./ Хавагнах шинж ямар шалтгаантай үүсэж болох вэ?

1. Зүрхний дутагдал

2. Бөөрний дутагдал

3. Уураг дутагдал

4. Харшил буюу Квинкийн хаван

5. Судас бөглөрөх хам шинж

/325./ 2 сараас 5 хүртэлх насны хүүхдэд ямар аюултай ерөнхий шинжийг бага эмч үзлэгийн явцад шалгах ёстой вэ?

1. Хүүхэд уух буюу хөхөх чадвартай байна уу?

2. Уусан бүхнээ бөөлжиж байна уу?

3. Хүүхэд татсан уу? Ухаангүй байна уу?

4. Хүүхэд уух, хөхөхдөө муудсан уу?

5. Хүүхэд өндөр халуурч, тайван биш болсон уу?
- /326./ Гэр бүлийн хүчирхийллийн далд шинжүүдийг бага эмч хэрхэн илрүүлэх вэ?
1. Нөхрийн дэргэд юм ярихгүй байх эсвэл богино өгүүлбэрээр товч ярих
 2. Нөхөртөө зодуулж авсан гэмтлээ нуух гэж оролдох, худлаа ярих
 3. Ээж аавдаа, эсвэл хүүхэддээ нөхрөөс нууцаар юм худалдан авч өгөх
 4. Толгой өвдөх, нойр муудах, зүрхээр хатгуулах зэрэг сэтгэл хямарлаас үүдэх эмгэгүүдийг ойр ойрхон дурьдах
 5. Сэтгэл зовиносон байдал, харц, сэтгэл түгших буюу гутрах эмгэгийн шинжүүд илрэх
- /327./ 20 долоо хоногтой жирэмсэн эхэд ямар зөвлөгөө өгөх ёстой вэ?
1. Жирэмслэлттэй холбоотой хууль зүйн ойлголт.
 2. Төмрийн бэлдмэл, фолийн хүчил уухын ач холбогдол
 3. Зулбалтаас сэргийлэх тухай
 4. Төрөлтийн тухай
 5. Жирэмсний эмзэг байдлын тухай
- /328./ 3 настай 14 кг жинтэй хүүхэд 6 хоног суулгасан зовиуртай, үзлэгээр хүүхэд тайван, шингэн өгөхөд ам нь цангасан, ховдоглон ууж байв. Хүүхдийн нүд хонхойгоогүй, арьсны хуниас удаан арилж байсан. Хүүхдийг үнэлж, ангилж, эмчил.
1. Шингэн алдаагүй гэж ангилна
 2. Шингэн алдсан гэж ангилна
 3. Шингэн алдсан гэж ангилаад 400 мл ШСД уусмал аягаар бага багаар 4 цагийн турш уулгана.
 4. ШСД уусмалыг 75 мл/кг жинд тооцоолон 4 цагийн турш бага багаар уулгана
 5. Хүнд шингэн алдсан гэж ангилаад хураагуур судсанд шингэн юүлнэ
- /329./ Жирэмсний явцад ямар эмгэг илэрвэл жирэмсэн эмэгтэйд бага эмч дараах шатны эмнэлэг рүү шилжүүлэх вэ?
1. Жирэмсэнтэй хавсарсан эмгэгтэй
 2. Онош тодорсон олон урагт жирэмсэн
 3. Төрөх хугацаанаас 1 сарын өмнө ураг хөндлөн эсвэл буруу байрлалтай нь тодорхой байгаа
 4. Энэ жирэмслэлтийн явцад үтрээгээр цус гарч байсан өгүүлэлтэй эсвэл одоо цус гарч байгаа
 5. Төрсний дараа үрийн хоолой боолгох эсвэл ерөндөг тавиулах хүсэлтэй
- /330./ Депо-провераг хэрэглэхийг хориглох заалт юу вэ?
1. Жирэмсэн
 2. Зүрхний цус хомсдох эмгэг, цусны даралт ихтэй ба цус өтгөрөх эмгэгтэй.
 3. Элэгний эмгэг ба хөхний хорт хавдар
 4. Бэлгийн замын халдвар
 5. Хөхүүл
- /331./ Дутуу төрөхөд юу нөлөөлж болох вэ?
1. Жирэмсний хожуу үеийн хордлого
 2. Жирэмсэн үедээ өвчин тусах
 3. Жирэмсэн үедээ хүнд хүчир ажил хийх, ядрах, сэтгэл санааны таагүй байдал
 4. Урьд өмнө зулбадаг, дутуу төрдөг байсан, өмнөх жирэмслэлт ба төрөх үеийн эмгэгүүд, олон удаа аборт хийлгэх
 5. Бэлгийн замын халдварууд